

НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2015 оны 12 сарын 07

Улаанбаатар хот

Жилийн үйл ажиллагааны талаар

Тус төв нь 2015 оны 44 зүйл төлөвлөгөө гарган улирал, хагас, жилээр дүгнэн ажилласан. Монгол Улсын засгийн газрын тогтоол-4, Нийслэлийн Засаг даргын захирамж-2, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын тушаал-30, Нийслэлийн эрүүл мэндийн газрын албан даалгавар-4, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол- 2, Эрүүл мэндийн сайдын тушаал-3, Нийслэлийн архивын газрын даргын тушаал-1, Өмчийн харилцааны газрын даргын тушаал-1 хугацаанд хийгдсэн ажил, биелэлтийг зохих шатны байгууллагад хүргүүлж ажилласан. Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө 100 хувийн биелэлттэй ажилласан.

1. Жилийн зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа

Эрүүл аюулгүй Улаанбаатар хот зорилтын хүрээнд нэгдсэн төлөвлөгөө гарган ажиллаж зохих шатны байгууллагуудад хугацаанд нь мэдээ мэдээллийг явуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 12 сарын 08- ны 318 тоот тогтоол “Үндэсний түргэн тусламжийн сүлжээ” хөтөлбөрийн хүрээнд 2 ажлын хэсэг байгуулагдаж Түргэн тусламжийн удирдамж, гарын авлага болон автомашины стандартыг боловсруулан мэргэжлийн зөвлөл, стандарчлал хэмжил зүйн газарт хүргүүлсэн. Мөн дуудлагын норм, нормативийг боловсруулан эмнэлэг үйлчилгээний удирдамжийг Эрүүл мэнд спортын яам, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын ажлын хэсэгтэй хамтран ажиллаж байна.

2. Нийслэлийн нийгэм эдийн засгийн дараах зорилтуудын хүрээнд төлөвлөгөө гарган 100 хувийн биелэлтэйгээр ажиллалаа. Үүнд:

- Нийслэлийн засаг даргын 2015 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/304 дүгээр захирамжийн дагуу тус төвийн захирлын 2015 оны 05 сарын 01-ны өдрийн А/14 тоот ажлын хэсэг байгуулах тухай тушаал гарган төв болон салбаруудын хэмжээнд болзолт уралдааны ажлын төлөвлөгөөг 36 зүйлтэйгээр гарган ажиллаж биелэлт 100 хувь байлаа. Тус аяны хүрээнд Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагын хэмжээнд 3-р байр эзэлсэн.
- Иргэдийг орон сууцын зээлд хамруулах ажлыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Төрийн орон сууцын 8 хувийн зээлд-12 ажилтан, төрийн албан хаагчийн орон сууцжуулах хөтөлбөрт 3 ажилтан хамрагдсан.
- Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсны дагуу, тамхины тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр нийт ажилчдаас тамхи татдаг хүмүүсийн судалгаа гаргасан. Тамхи татдаг 80 ажилтантай 1 –1,5 жилийн гэрээ хийж гарын үсэг зуруулж хяналт тавьж, сургалт явуулж, болзолт уралдаан зарлаж өдөрлөг зохион байгуулж ажилласны үр дүнд нийт 29 ажилчин тамхинаас бүрэн татгалзаж тус бүр 1 сарын цалингийн урамшуулал авсан. 80- 100% 29- 36,25% нь тамхинаас татгалзсан 63,75% нь ажлын байр, байгууллагын хашаанд тамхи татахгүй хэрэглээг багасгасан.

Судалгаагаар өдөрт 1 хүн дунджаар 1 хайрцаг тамхи татдаг 3000 төгрөгийн үнэтэй сард 90000 төгрөг, жилд 1080000 төгрөгийн тамхи татдаг бол 29 ажилчин өдөрт 87000 төгрөг, сард 2610000 төгрөг жилд 31320000 төгрөгийн эдийн засгийн болон эрүүл мэнддээ маш их хөрөнгө оруулалт хийсэн .



- Хэв журам сахиулах, гэмт хэрэг ба захиргааны зөрчилтэй тэмцэх ажлыг хариуцна зорилтын хүрээнд 6 удаагийн сургалт, 6 камерын дуран байршуулж энэ хугацаанд гэмт хэргийн тохиолдол гараагүй.
- Гадна талбай, дотор орчны шаардлагатай хэсгийг хянах зорилгоор гадна талд хяналтын 2 камер, гараж дотор 14 хяналтын камерын суурилуулсан. Дотоод хяналтын камер нь 24 цагийн бичлэг хийгдэж, нийт 48 хоног хадгалагдах сервертэй. Ингэснээр дотоод хяналт сайжирч, ажилчдын ажиллах тухтай орчин нөхцөл бүрдэж байна.



- Гадна болон дотор талд эмнэлгийн байрыг байнга хянах зорилгоор камерийн системийг тавьж байршуулсан байгаа. Нийт 8 газар камер байршуулсан байгаа. Үүнд : гадна талд 2 ш, дотор талд давхар бүр камертай болсон.



- Баянзүрх салбарын гадна талбай, дотор орчны шаардлагатай хэсгийг хянах зорилгоор гадна талд хяналтын 2 камер, гараж дотор 1, 2-р давхарт 1 хяналтын камерын тус тус суурилуулсан. Хяналтын камер нь 24 цагийн бичлэг хийгдэж, нийт 48 хоног хадгалагдах сервертэй. Ингэснээр дотоод хяналт сайжирч, ажилчдын аюулгүй орчин нөхцөл бүрдсэн.
- Хан-уул салбарын гараж болон давхруудад хяналтын камер байрлуулж гадна болон дотор орчны шаардлагатай хэсгийг байнга хянаж байна.



- “Мансуурах бодисын эсрэг дэлхийн өдөр” 6-р сарын 26-нд болдог ба Монгол улсын ЭМСС-ийн тушаал өөрчлөгдсөнтэй холбоотой ажлын хүрээнд 1-р ээлжийн эмийн санч сувилагч О.Учралт салбарын эмч нарт мансуурах сэтгэц нөлөөт эм хэрэглээ, тушаал зааврын өөрчлөлтийн талаар сургалт орсон. Эмийн сангийн сувилагч О.Учралт “Мансууруулах, сэтгэц нөлөөт эмийг хэрэглэх журам” хавтас нээсэн.



- Мансууруулах сэтгэц нөлөөт эмийн хэрэглээг судлахад Баянзүрх дүүрэг 15-р хороо шинэ сонголт Бямбацогт 49 н/ эр циррозтой өвдөөд гэсэн дуудлагад нийт 16 өдөр буюу 57 удаа үйлчлүүлж эмнэлгийн тусламж үйлчилгээг авсан байна. Өдөрт 2-6 удаа үйлчлүүлж морфин гидрохлорид 1%-1мл тариагаар тариулж хэрэглэсэн байна. Нэг удаагийн морфины зардалд.
 - Морфин -1320 төг, тариур-85 төг, спирттэй хөвөн-5 төг, амны хаалт-70 төг, улавч-135 төг нийт 1615 төгрөг болон нийт км-т зарцуулсан шатахууны зардалд 10050 төгрөг бүгд 11665 төгрөгийн зардал гарч байна Мөн нийт 16 өдрийн 57 удаагийн хатгалт хийлгэсэн байна. Өдөрт 2-6 удаа очиж эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. 57 удаагийн тарилгын зардал нь 92055 төгрөг, шатахууны зардалд 664905 төгрөг нийт 752550 төгрөгийн зардал гарсан байна.
 - Иймд мансууруулах сэтгэц нөлөөлөх эмийн хор уршгийг иргэдэд ойлгуулах шаардлагатай байна.



- Нийслэлийн түргэн тусламжийн үйлчилгээний бүтэц, зохион байгуулалтыг шинэчилснээр түргэн тусламжийн 103 үйлчилгээг дүүрэг бүрд байгуулна зорилтын хүрээнд Хан-уул салбарын үйл ажиллагаа 2-р улиралд ашиглалтад орсноор тус дүүргийн дуудлагын хүлээгдэл буурах болсон. Нийслэлийн Засаг даргатай Түргэн

Тусламжийн салбар барих “Төслийн зураг төсөл боловсруулах-барих-шилжүүлэх онцгой эрх /концесс/-ээр хийсэн гэрээний дагуу Хан-Уулын салбар 2015 оны 05 сарын 28-аас өдөр тутам 8 их эмч, 3 сувилагч ээлжийн зохицуулагчтайгаар үйл ажиллагаагаа эхлүүлэн өдөрт 110-130 дуудлагад үйлчилж хүлээгдэл Хан-уул дүүргийн насанд хүрэгчдийн дуудлагын хүлээгдэл 7,4 хувиар буурч, яаралтай дуудлагын 20 минутын очилт 3.2 хувиар нэмэгдэж байгаа нь газар дээр нь үзүүлэх түргэн тусламжийн хүртээмж, чанар нэмэгдэж байна. Улмаар 2016 онд тус дүүргийн хүүхдийн дуудлагад үйлчилснээр түргэн тусламжийн цогц үйлчилгээ бүрдэх болно.

- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Нийслэлийн Онцгой байдлын албатай хамтран “Амилуулах суурь тусламжийн сургалт”-ыг зохион байгуулсан. Тус сургалтад ажилтнуудаас гадна улаан загалмай нийгэмлэгийн 123 хүн хамрагдсан. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Журам батлах тухай” 399 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Төв болон Баянзүрх салбар, Сонгино хайрхан салбар, Авто баазын нийт 163 ажилтан ажиллагсад газар хөдлөлтийн гамшгийн үеийн аврах гарцын схемийн дагуу тус тусын цугларах цэг

дээр штабын дарга болон туслахуудын хамт цугларч 98% ирцтэйгээр мэдээлэл өгсөн. 2015 оны 03 дугаар сарын 26-нд “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх” болон гамшгаас хамгаалах төлөвлөгөөний талаар 192 эмч ажилчдад 15 минутын мэдээллийг гамшгаас хамгаалах штабын дарга С.Ариунболд өгсөн. **Ч...+15 минут**



3. Төрийн архивд нөхөн бүрдүүлэлт хийх

- 2015 оны 06 сарын 03-ны өдрийн баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар 2004-2009 оны захирамжлалын баримт бичгийн дутуу бүрдэлтэй хавсралт дутуу баримтыг нөхөн бүрдүүлж 2015 оны 06 дугаар сарын 10-ны 67 тоотор хүргүүлсэн.
- Нийслэлийн Засаг даргын захирамж 2015 оны 06 дугаар сарын 16-ны А/509 захирамж, Нийслэлийн засаг даргын тамгын газрын 2015 оны 06 сарын 22-ны өдрийн 03/2037 тоот албан бичгийн дагуу тус төв дээр “Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийг” зохион байгуулж, дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Үүнд:

- Архив, албан хэрэг хөтлөлт, мэдээлэл технологи, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг угтаж 40 нэр төрлийн төлөвлөгөө гарган ажилласан.
- Улсын үзлэгийг угтаж тус төвийн удирдлагуудад Нийслэлийн Архивын газрын сургалт хариуцсан мэргэжилтэн Н.Оргилболд “Баримт бичгийн стандартын тухай ойлголт, баримт бичгийн бүрдлүүд тэдгээрт тавигдах шаардлага” сэдвээр ажлын байран дээр сургалт арга зүйн туслалцаа, зөвлөгөө авсан.



- Улсын үзлэгийг угтаж “Монгол хэл, бичгийн боловсролыг сайжруулах тухай” Засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоолын хүрээнд зохион байгуулсан ажлын хүрээнд тус төвөөс хүний нөөцийн алба, бичиг хэргийн ажилтны компьютерт “Болор” алдаа шалгадаг программ суулгасан. Мөн нийт ажилчдад сургалт зохион байгуулж, “Журамласан 700 үг” Төрийн хэлний зөвлөлийн 2011 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд захиргааны ажилчдаас нийт 18 хүнээс сорилын тестээр шалгалт авч зарим шаардлагатай үгсийг тайлбарлан дүнг танилцуулан холбогдох материал гарын авлагаар хангаж ажилласан.
- Архив албан хэрэг хөтлөлтөнд мэдээллийн технологи нэвтрүүлэх талаар Архивд шаардагдах орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр байгууллагыг бүрэн хангаж, байгууллагад бий болж буй цахим мэдээллийг CD, DVD-нд бичиж архивд хүлээлгэн өгсөн. Техник хэрэгслийн найдвартай ажиллагааг хангаж шаардлагатай суурин компьютерүүдэд тог баригч суурьшуулсан.

**АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН УЛСЫН ҮЗЛЭГ**

Байгууллагын цахим хуудсанд албан хэрэг хөтлөлтийн стандарт, сургалтын материал зэргийг байршуулсан ба улсын үзлэгийн холбоотой мэдээ мэдээллийн баннер байршуулан ажилласан. Мөн мэдээлэл технологийн ажилтан С.Бямбасүрэн уг шалгалтын эрүүл мэндийн байгууллагыг шалгах комисст орж Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн хувийн болон өрхийн нийт 42 эмнэлгээр архив албан хэрэг хөтлөлтийн шалгалтын комисст орж мэдээлэл технологийн үйл ажиллагааг шалгаж, заавар зөвлөгөө өгсөн.

- Байгууллагын албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын нэгдсэн дүнгээр Байгууллагын архив-95,4, Албан хэрэг хөтлөлт-91, Мэдээллийн технологи- 97,3, Төрийн байгууллагын зохион байгуулалт-78,5 нэгдсэн дүн **91,6 буюу “А”** үнэлгээтэй дүгнэгдсэн.

4. Эмчилгээ оношилгооны шинэ техник технологийг нэвтрүүлсэн талаар.

- Нийслэлийн хөрөнгө оруулалтаар Түргэн тусламжийн үйлчилгээнд ашиглагдаж буй 89 бүрэн тоноглогдсон /амьсгалын аппарат, хяналтын монитор, дефибрилятор, сорох аппарат/ зэрэг нийт 108 ширхэг тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа тогтмолжуулан техник ашиглалтын болон аюулгүй ажиллагааны зааврын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласнаар 98 хувийн гүйцэтгэлтэй байна.



Амьсгалын аппарат



Хяналтын монитор




Сорох аппарат



Дефибрилятор

- Түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулах хүрээнд даралтын аппарат 86 ширхэг, хүчилтөрөгчийн редуктор 12 ширхэг, сахар хэмжигч аппарат 19 нэмэгдүүлснээр эмнэлгийн хэрэгслийн оношилгоо өмнөх мөн үеэс 22.1 хувиар нэмэгдсэн.



Сахар хэмжигч аппарат



Хүчилтөрөгчийн редуктор



Даралтын аппарат

- Төсөв, санхүүгийн сахилга батыг ханган ажиллах чиглэлээр аудитын байгууллагатай жил бүр явцын болон гүйцэтгэлийн хөндлөнгийн хяналт шалгалтыг тогтмол хийлгэж зөрчил, дутагдалгүй ажиллаж байна.
- Төсвийн ил тод байдал, ард иргэд болон хөндлөнгийн хяналт, нээлттэй байдлыг хангах чиглэлээр “Шилэн данс”-ыг нэвтрүүлэн

- ✓ Төсвийн зарцуулалт, гүйцэтгэл
- ✓ Санхүүгийн тайлан баланс
- ✓ Аудитын зөвлөмж, дүгнэлт
- ✓ Гаднаас бэлтгэн нийлүүлэх 5 сая төгрөгөөс дээших татан авалт
- ✓ Хөрөнгөтэй холбогдсон шийдвэрүүдийг цахим хэлбэрээр мэдээлж байна.

Цаашид шилэн дансны хэрэгжилтийг улам сайжруулж, төсвийн хөрөнгийн аливаа зөрчилгүй ажиллахаар эрхэм зорилгоо тавин ажиллаж байна.



Дефибриллятор, амьсгалын аппарат, сорох аппарат, өвчтөний хяналтын монитор гэсэн 4 төрлийн нийт 220 ширхэг тоног төхөөрөмж 55 автомашинд шинээр суурилагдсан. Зөөврийн зүрхний бичлэгийн аппарат 12 ширхгээс эрчимт эмчилгээний дуудлагын эмч нар 7 ширхгийг дуудлагад авч гаргадаг ба нөөцөд 5 ширхэг байна. Мөн 75 түргэн тусламжийн машин байдгаас 73 буюу 94,8% нь 10 литрийн цэнэгтэй хүчилтөрөгчийн баллонаар хангагдан эмнэлэг үйлчилгээнд явж байна. Хоёр салбарын үзлэгийн өрөөнд 40 литрийн хүчилтөрөгчийн баллон суурин байна. Зөөврийн 10 литр-25 ш, 5 литр-15 ш, 3 литр-20 ширхгийн хүчилтөрөгчийн баллон нөөцөд байна.

Энэхүү тоног төхөөрөмж суурилагдсанаар анхан шатны тусламж үйлчилгээ сайжирч эмч нарын газар дээрх болон эмнэлэг хүртэлх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжирсан.

2014 оны эхний 11 сарын байдлаар бодитоор очиж үзсэн 283108 дуудлага хүлээн авснаас нийт дуудлагын 15% буюу 42466 дуудлагад нь тоног төхөөрөмжийг ашиглаж өвчтөнд түргэн тусламжийг шуурхай хүргэсэн. 2015 оны эхний 11 сарын байдлаар бодитоор очиж үзсэн 306478 дуудлага хүлээн авснаас нийт дуудлагын 42% буюу 128721 дуудлагад нь тоног төхөөрөмжийг ашиглаж өвчтөнд түргэн тусламжийг шуурхай хүргэсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад тоног төхөөрөмжийн ашиглалт нэмэгдсэн байна.

Энэ онд “Баянгол Мед” ХХК аас 25,729,935 төгрөгийн ЭКГ, ЭХО, Дефибриллятор 3 ширхэг аппаратыг 2015.07.17 ны А-69 нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын тушаалаар хүлээн авсан. Мөн “Чоногол” ХХК-аас 24,310,000 төгрөгийн ЭКГ-1, Автоклав-1, Дефибриллятор-1, Эмийн шүүгээ-2 аппаратыг 2015.10.16- ны өдрийн А-87 нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын тушаалаар хүлээн авсан. Эдгээр тоног төхөөрөмжийг ажиллагааг шалган хүлээн авч хариуцсан мэргэжилтэн нарт сургалтыг хийн хүлээлгэн өгсөн. Автоклав аппаратыг шинээр нээгдсэн Хан-Уул салбарт суурилуулж ажиллагааг шалган хүлээлгэн өгөв. Хариуцсан мэргэжилтэн нарт сургалтыг хийв.



Дефибриллятор



ЭКГ аппарат



Эхо аппарат



ЭКГ аппарат




Эмийн шүүгээ



Автоклав




Дефибриллятор



- 2014



- 2015



- 2014 он




- 2015 он

- Эрүүл мэндийн газраас 2015.08 сард дефибриллятор, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, зөөврийн ЭХО аппарат тус бүр нэг ширхэг хүлээн авсан. Байгууллагын нийт эмч нарт аппарат тус бүр дээр хэрхэн өвчтөнийг оношлох, хэрхэн аппаратыг ажиллуулах сургалтыг нийтдээ 8 удаагийн сургалтаар 16 эмчид зохих мэдлэгийг эзэмшүүлсэн.




- Нийслэлийн Эрүүл Мэндийн газраас зарласан “Осол гэмтэл, түлэгдэлтээс сэргийлэх сарын ”-ын аяны хүрээнд Нийслэлийн өрхийн эмнэлгийн 865 эмч сувилагч нарт “Гэмтлийн суурь тусламж” сэдэвт сургалтыг 45 хоногийн турш 1 кредитээр зохион байгуулснаар салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирсан. Мөн хамрагдагсдын мэдлэг, дадал 26.8-.30.2 хувиар нэмэгдсэн байна.



- Бичиг баримт хөтлөлт- бүгдээрээ хийцгээе” аяны хүрээнд Эмч нарын мэдлэгт нэмэрлэн хүүхдийн зонхилон тохиолдох өвчлөлийн талаар онолын хавтастай болсноор яаралтай хүүхдийн өвчлөлийн үед хурдавчилсан үнэлгээтэй болсон.
- “Хүүхдийг эрэмбэлэн ангилах, түүнд үзүүлэх яаралтай тусламж” хичээл хүүхдийн мэргэжилтэн 3.Энхцэцэг 45 минутын сургалтад 123 эмч, сувилагч хамрагдсанаар дуудлагын нэн аюултай шинжүүдээр эрэмбэлэн хугацаа алдахгүй болсон.
- Автомашины тоног төхөөрөмжийг хэрэглэх аяны хүрээнд 67 их эмч, 83 жолооч, 28 сувилагч буюу 98.4 хувийн хамрагдалтай байсан. Тухайн дуудлагад явж байгаа их эмч, жолооч, сувилагч нарт яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай өвчтөнд цаг алдалгүй эмнэлэг хүртэл тээвэрлэхэд чухал ач холбогдолтой юм.



- “Эмнэлгийн байгууллагын хог хаягдлын менежмент” сэдвээр Баянзүрх салбарт ээлжийн 47 эмч, сувилагч нарт сургалт явуулснаар эмнэлгийн гаралтай хог хаягдлын мэдлэг 36.8 хувиар нэмэгдсэн.



- “Бүтээлч сэтгэлгээг дэмжье” 3 сарын аяны удирдамжийг боловсруулан, 9 зүйлтэй төлөвлөгөө гарган батлуулан ажиллаж байна. Аяны хүрээнд Хан-уул салбарын хэмжээнд ажилчид нийт 1420000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Үүнд, 3-р ээлж 887000 төгрөгийн 15 мод суулгасан ба бусад тохижилтын ажил хийгдсэн.



- Сонгинохайрхан салбарын 2 дугаар ээлжийн хамт олон 1-р сард "Картаа бичдэг хамт олон болцгооё " сарын аяныг ээлжийн эмч нарын эмч нарын дунд зохион байгуулж ажилласнаар эмч нарын карт бичилт цаг хугацаандаа бичигдэж, карт бичилтийн чанар сайжирсан.
- Сонгинохайрхан салбарын 3 дугаар ээлж хамт олноороо “Эх барихын тусламж үйлчилгээ” сэдэвт нэг сарын аян зохион амжилттай зохион байгууллаа. Уг аянд ээлжийн эмч сувилагч нар нэг нэг ажил зохион явуулсан. Тус аяны хүрээнд:
 - “Эх барихын тусламж үйлчилгээгээр 3 ээлжийн эмч нарын дунд мэтгэлцээн амжилттай зохион байгуулсан ба эх барих явцад гарах алдаа эрсдлийн судалгаа хийж, үр дүнг нийт эмч, сувилагч нарт танилцуулж, цаашид тохиолдох эрсдлээс хамгаалах үр дүнтэй судалгаа болон тус төвийн гэрийн төрөлтийн тусламж үйлчилгээний сэтгэл халамжид түүвэрчилсэн асуулгын аргаар судалгаа хийхэд үр дүн 85-90% нь гэрт төрсөн эхчүүд болон ар гэрийнхнээс түргэний эмчийн үйл ажиллагаанд сайн гэсэн үнэлгээ өгсөн. Энэ нь тус төвийн эмч нарын тусламж үйлчилгээ, мэдлэг чадвар сайн буйг илэрхийлж байгаа юм.
 - “Жирэмсэн эхчүүд” болон “Төрсөн эхэд үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ” сэдэвтэй гарын авлага өөрийн нөөц бололцоогоо ашиглан 235 эхэд тараах материал болгон тарааж өглөө.
- НЭМГ-ын даргын 2014 оны 4 дүгээр сарын 29 ний өдрийн А/50 дугаар тушаалын дагуу аяныг зохион байгуулж хэрэгжүүлэхээр тус төвийн захирлын А/29 тоот тушаалаар байгууллагын эрүүл мэндээ дэмжигч бүлэг 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, төлөвлөгөө гарган батлуулж ажилласан.



- Баянзүрх салбар, авто бааз дээр чийрэгжүүлэлтийн 2 кабинетийг орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангаж тогтмол ажиллуулж хэвшүүлсэн, ажлын бус цагаа зөв боловсон өнгөрүүлэх, эрүүлжих нөхцөл бололцоогоор хангагдсан “ Эх орон телевизээр ажлын

өдрүүдэд өглөө бүр 11- 12 цагийн хооронд ажлын байрны дасгалыг зааж хийлгэж байгаа баазын болон Баянзүрх салбар чийрэгжүүлэлтийн кабинетэд энэтхэгийн залуужуулах 5 дасгал, хийн дасгал, бясалгал, зааж өгч хийлгэж хэвшүүлж давхардсан тоогоор нийт 3420 хүн хичээллэсэн. Авто баазын чийрэгжүүлэлтийн танхим фитнесийн чиглэлээр ажилладаг.

- Хүүхдийн дуудлагыг хүлээн авч, тусламж үйлчилгээг үзүүлэх бэлтгэл ажлын хүрээнд “Хүүхдийн дуудлагын тусламж, үйлчилгээ” сэдэвт 2 сарын аянг зохион байгуулсан. “Хүүхдийн яаралтай тусламжийн эрэмбэлэн ангилалт” сэдвээр ээлжийн эмч нараас сургалтын өмнө 70% бөглөсөн бол сургалтын дараа 85% бөглөсөн байсан тул, зохион байгуулсан сургалт нь эмч нарын мэдлэгт хангалттай сайн нөлөөлсөн гэж дүгнэв. “Жирэмсэн эхчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах сарын аяны” хүрээнд 55 эмч нарт сургалт, гэрийн төрөлтийн 16 дуудлагын хуудсанд ижил мэргэжилтний үзлэг хийсэн. Мөн артерийн даралт ихсэх, ухаан алдах, татах, нүд бүрэлзэх, толгой өвдөх сэдвээр орсон сургалтыг үр дүнг сорилоор үнэлэхэд 90%-ийн үнэлгээ авсан.
- Зохицуулагч нарын санаачлагаар “Амьддаа бие биеэ хайрлая ” сайн үйлсийн аян төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран өрнүүлж дүүргийнхээ хэвтрийн хүнд өвчтөнг сонгон авч улирал бүр эмнэлгийн болон хүмүүнлэгийн тусламж үе шаттайгаар зохион байгуулж байна. Энэ удаад Сонгинохайрхан дүүргийн 1-р хороо Толгойтын 105-3а тоотод оршин суугч Б. Санжидхорлоо 38 настай эмэгтэй хэвтрийн 16 болон 10 настай 2 хүүгийн асаргаанд байдаг. Онош: Нижний парапарез .



Чанарын албанаас Олон улсын эмч нарын баярыг тохиолдуулан чанарын өдөрлөгийг Сонгино хархан салбартай хамтран зохион байгуулсан.



- Чанарын албаны шилжин явах цомыг байгууллагын хэмжээнд жил бүр аялуулдаг. 2014 оны ажлаа үнэлүүлсэн Сонгинохайрхан салбарын хамт олонд шилжин явах цомыг мөнгөн шагналын хамт гардуулав.
- 2015.03.31-ны олон улсын эмч нарын өдрийг тохиолдуулан их эмч нарын “Чанарын өдөрлөг”-ийг “Чингис зочид буудал”-д зохион байгуулсан ба “Чанарыг эрхэмлэгч” цол тэмдгээр 3-н их эмч, “Тэргүүний залуу алтан медаль”-иар 2 их эмч, “Хөдөлмөрийн алдар” цол тэмдгээр 3-н их эмч, “Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч” медалиар 2 их эмчийг тус тус шагнаж урамшуулсан.



- Өдөрлөгт “КРКА”ХХК-тай хамтран ажиллаж нийт салбар нэгжүүдийнхээ ажил үүргээрэй шалгарсан их эмч нартай “КРКА” нэрийн бараагаар шагнаж урамшуулав. Мөн ажил үүргээрэй манлайлсан 5-их эмчид чанарын өдөрлөгийн

хүрээнд өргөмжлөл гардуулан өгөв

- **“Сувилагчийн нэг өдөр”** нээлттэй хаалганы өдөр зохион байгуулсан тухай: Сувилагч мэргэжлийг сурталчлах, сувилахуйн тусламж үйлчилгээний мөн чанарыг ойлгуулах, мэдээлэл өгөх, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх, байгууллага хамт олны оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Сувилагч мэргэжил миний бахархал” нээлттэй хаалганы өдөрлөгийг 2015 оны 05 дугаар сарын 09- ны өдөр Нийслэлийн түргэн тусламжийн төвийн Баянзүрх, Сонгинохайрхан салбарууд дээр зохион байгуулсан. Нийт 148 эцэг эх, үйлчлүүлэгчийн артерийн даралт, биеийн өндөр, жинг үзсэн ба 12 хүнд зүрхний цахилгаан бичлэг хийсэн.



- Улаан бурхан өвчин, салхин цэцэг, гар хөл амны халдварт өвчин, хүүхдийн суулгалт өвчин, гэдэсний халдвар, халуурах, таталт, нярайн асаргаа сувилгаа, аюултай ерөнхий шинж илэрвэл хаана хэнд хандах вэ?, сайн дурын шинжилгээ хаана өгөх вэ?, нойрын хямрал зэрэг сэдвүүдээр нийт 150 ш гарын авлага бэлтгэж эцэг эх, үйлчлүүлэгч нарт эрүүл мэндийн боловсрол олгосон.



- Олон улсын сувилагчдын өдрийг угтаж “Донорын өдөр”- өөр 2015 оны 5 дугаар сарын 4. 5. 6-ний өдрүүдэд нийт 12 сувилагч 4800 мл цусыг сайн дураар өөрсдийн санаачлахаар цусаа бэлэглэсэн.



- Нийт ажилтан албан хаагчдын бие бялдрын сорилд сувилагч нар идэвхтэй оролцож А-16, В- 8, С- 10 үнэлгээтэй дүгнэгдсэн.



- Улаан бурхны давтан вакцинд сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг бүрэн хамруулсан.
- ЭМС-ын 47-р тушаал, НЭМГ-ын А/17 тушаалын дагуу “Эх хүүхдийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулъя” болзолт уралдааны дагуу “Сувилагчийн нэг өдөр” нээлттэй хаалганы өдөрт нийслэлийн түргэн тусламжийн төвийн Сонгино хайрхан салбарын Д.Мягмарсүрэн ахлагчтай 1-р ээлжийн эмч нар барилга угсралтын “САНК” ХХК- тай хамтран 2015 оны 4 дүгээр сарын 28-нд “САНК” ХХК -ийн ‘Хөдөлмөрийн аюулгүй байдлыг эрхэмлэх аян’ - ний өдөрлөгт зориулж САНК” ХХК- ийн нийт ажилчдад чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг хийж зөвлөгөө өгөв.
- Нийт 58 ажилчид үзлэгт хамрагдсан бөгөөд үзлэгээр биеийн жин өндрийн харьцаа, артерийн даралт, өлөн үеийн цусан дах сахарын хэмжээг тодорхойлж чихрийн шижин өвчний эрсдэлд хүчин зүйлс болон уг өвчнөөс урьдчилан сэргийлэх аргын талаар зөвлөгөө өгсөн.
- Хоолны өдөрлөгөөр: Ажлын онцлогт тохирсон ажилчдын өдөр тутмын хоолны амт чанарыг сайжруулах болон эрүүл зөв хооллох талаар анхаарч мөн хоолны нэр төрлийг сайжруулах зорилготой ажиллаж байна.



- Сувилагчийн нэг өдөр’ сэдэвт нээлттэй хаалганы өдрийг тохиолдуулан ADRA Хүүхдийн боловсролыг дэмжих төрийн бус байгууллагатай хамтран Амьдралын түвшин доогуурх 3-15 насны 97 хүүхдүүдэд Түргэн тусламжийн төвийн хүүхдийн эмч Р.Адхүү, 1-р эмнэлгийн ЧИХ ХАМАР ХООЛОЙ эмч нар, СБД- ын эрүүл мэндийн нэгдлийн дотрын эмч нар, ЧД-ийн эмч нар, ЭМШУИС- ийн 4,5- р курсийн оюутнуудтай хамтран үзлэг хийж, Яаралтай тусламжийн талаар сургалт явуулсан.



- Эрүүл мэндийг хамгаалах өдөр буюу 4-р сарын 7-ны өдрийг угтсан MCS Coca-Cola” ХК-тай хамтран ажилладаг талаар “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” сонинуудад 4-р сарын 4-нд ярилцлага хийсэн.
- Ингэснээр тухайн газар гэнэтийн тохиолдлоор унаж гэмтсэн хүнд 103 ирэхээс өмнө яаралтай тусламж үзүүлж хүний амь нас, цаашид гарах хүндрэлийг багасгах зорилгоор ард иргэдэд анхны мэдэгдэхүүн олгоход оршино
- Сонгинохайрхан дүүргийн 3-р ээлжийн Зохицуулагч Халиунаагийн санаачилгаар “Тэсо” ХХК-ны ажилчдад “Артерийн даралт ихсэх” Түүнээс урьдчилан сэргийлэх, Яаралтай тусламжийн үед үзүүлэх арга хэмжээ сэдэвт 2 хичээлээр сургалт орж, артерийн даралт үээж, цусны сахар үээж зөвлөгөө өгсөн.



- Дуудлагын 137 эмч, 36 сувилагч, 118 жолооч нарт Амилуулах суурь тусламж , Эбола болон Крона вирусын халдвар, Зооноз, тарваган тахал өвчний үед хамгаалах хувцсыг зөв өмсөх болон тайлах дэс дарааллаар зохион байгуулсан. Сургалтын өмнөх сорил авахад нийт оролцогчид 53,9% байсан бол сургалтын дараах сорилд 83,9%-тай болсон нь үр дүнтэй байна гэж дүгнэлээ.



- 2015 оны 2-р улиралд 88 жолооч нарт Амилуулах суурь тусламжийн сургалтыг явуулж сургалтын өмнөх болон дараах сорил авч мэдлэг шалгахад нийт оролцогчид 58,1% байсан бол сургалтын дараах сорилд 81,2%-тай байсан.




- Шинээр ажилд орж буй эмч нарт Амилуулах суурь тусламж болон Осол гэмтлийн суурь тусламж, тоног төхөөрөмж эзэмших үр чадварт суралцах сургалтыг, шинээр ажилд орж буй жолооч нарт анхан шатны мэдлэг шалгах шалгалт авч, лекц дадлага хосолсон “Амилуулах суурь туслам болон Осол гэмтлийн суурь тусламж, тоног төхөөрөмж эзэмших үр чадварт суралцах сургалтыг зохион байгуулж үр дүнг тооцон ажиллаж байна.
- Дефибриллятор, амьсгалын аппарат, сорох аппарат, өвчтөний хяналтын монитор гэсэн 4 төрлийн нийт 220 ширхэг тоног төхөөрөмж 55 автомашинд шинээр суурилагдсан. Зөөврийн зүрхний бичлэгийн аппарат 12 ширхгээс эрчимт эмчилгээний дуудлагын эмч нар 7 ширхгийг дуудлагад авч гаргадаг ба нөөцөд 5 ширхэг байна. Мөн 75 түргэн тусламжийн машин байдгаас 73 буюу 94,8% нь 10 литрийн цэнэгтэй хүчилтөрөгчийн баллонаар хангагдан эмнэлэг үйлчилгээнд явж байна. Хоёр салбарын үзлэгийн өрөөнд 40 литрийн хүчилтөрөгчийн баллон суурин байна. Зөөврийн 10 литр-25ш, 5 литр-15 ш, 3 литр-20 ширхгийн хүчилтөрөгчийн баллон нөөцөнд байна.
- Байгууллагын нийт тоног төхөөрөмжийн нэгдсэн судалгааг гаргасан. Тоног төхөөрөмжийн хангалт болон инженерийн хяналтыг тоног төхөөрөмжийн инженер М.Мөнхбаатар Төв салбар, Баянзүрх салбар, Сонгинохайрхан салбар, Хан-Уул салбар болон автомашинд суурилагдсан нийт 16 нэр төрлийн 362 ширхэг тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Уг хугацаанд дараах ажлуудыг 2015 онд хийх ажлын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн.

- 2015 онд хийх төлөвлөгөөт ажлын дагуу дуудлагад гарч байгаа автомашинд суурилагдсан тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, цэнэглэлт, ашиглалт, халдвар хамгаалалт, О2-ийн хэрэглээ ашиглалтын талаар 7 хоногт 1-2 удаа шалгалтыг тогтмол хийж байна.
- Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 2013 онд Нийслэлийн Түргэн Тусламжийн Төвийн авто бааз нь бүрэн тоноглогдсон 28 автомашинаар эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байсан бол 2014 онд парк шинэчлэлт нэмж 27 автомашин бүрэн тоноглогдон 2015 оны байдлаар 55 бүрэн тоноглогдсон автомашинаар үйлчилж байна. Ингэснээр дуудлагын хүртээмж, чанар дээшилж, хүлээгдэл багассан.
- 2015 оны 8 дугаар сард хийсэн дотоод хяналтаар илэрсэн зөрчлийн дагуу Авто машинд ашиглагдах тоног төхөөрөмжүүдийн талаарх аюулгүй ажиллагааны зааварчилгаа танилцуулгыг байршуулсан.



- Үүнд: Сорох аппарат, дефибрилятор, амьсгалын аппарат, хяналтын монитор, Хүчилтөрөгч өгөх аюугүй ажиллагааны зааварчилгаа зэрэг багтсан. Ингэснээр автомашинд ашиглагдах тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл салбарын хэмжээнд бий болсон.
- Нийт 120 жолооч 75 автомашинтайгаар эмнэлэг үйлчилгээний байнгын бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Өдөрт 40 автомашин үйлчилгээнд ажиллаж , парк ашиглалтын коэффициент 53,3% техникийн бэлэн байдлын коэффициент 43,3%-тай байна.



- Өдөрт 24 цагаар 24 автомашин, 16 цагаар 13 автомашин, 8 цагаар 1 автомашин нийтдээ 37 мэргэшсэн жолооч, дуудлагын эмч нар Төв салбар, Хан-Уул салбар, Баянзүрх салбар, Сонгино хайрхан салбарууд дээр нийт 3 ээлжийн ахлагч, 9 зохицуулагчийн хамт 24:48 цагаар түргэн тусламжийг нийслэлийн иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүйгээр хүргэж байна.


5. Санхүүжилт, Хөрөнгө оруулалтын талаар

- Тус төвийн төсвийн тодотголоор санхүүжилт буурч 6,522.9 сая төгрөгийн төсөв батлагдсан. Эдийн засгийн хүндрэлтэй цаг үед төсвийн зарим зардлуудыг хэмнэх бодлогыг барьж 6,254.7 сай төгрөг болон буурсан. Эмнэлэг үйлчилгээг тасралтгүй явуулахад шаардагдах төсвийн хөрөнгө, нөөцийг зөв зохистой хуваарилан “Төсвийн

тухай хууль” бусад холбогдох хууль эрхзүйн актууд, НБББББ-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.

- Төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажиллах болсонтой холбоотойгоор Нийслэлийн Засаг даргатай Түргэн Тусламжийн салбар пункт барих “Төслийн зураг төсөл боловсруулах-барих-шилжүүлэх онцгой эрх /концесс/-ээр баригдсан Хан-Уулын салбарын дотоод тохижилтын ихэнхийг бага өртөг материал авч өөрсдийн ажилчдын хүн хүчийг ашиглан хийж ашиглалтад оруулав.
- Улсын төвлөрсөн төсвөөс санхүүжин байгууллагын ажлын онцлог байдлаас шалтгаалан ажиллагсдын цалин хөлс, хоол унааны нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ-д нийт төсвийн 84,8%-ийг, барилга ашиглалтын зардалд 1,6%-ийг, байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад зарцуулах бусад хангамж, үйлчилгээний зардлуудад 14 хувийг тус тус зориулаад байна.

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ (сая төгрөгөөр)




➤ **ӨРТӨГ, ЗАРДЛЫН ШИНЖИЛГЭЭ**

/2014.12.01-2015.12.01-ны дуудлагын тоотой харьцуулсан тооцоолол/

Нийт дуудлаганд ноогдох өртөг, хувь хэмжээ, нийт дуудлагын зардлын үзүүлэлт

	Нийт дуудлага	306478	Нийт дуудлагын эзлэх хувь, хэмжээ	Нийт зардлын эзлэх хэмжээ /сая.төг/
	Нэгж өртөг /төгрөгөөр/	20,408.36		
Үүнээс	Насанд хүрэгчид	270,537	88.3	5,521.2
	Хүүхдийн дуудлага	35941	11.7	733.5
Насанд хүрэгчдийн дуудлагаас				
Үүнээс	Үр дүнгүй дуудлага	11270	4.2	230.0
	Төрөх	23567	8.7	481.0
	Осол гэмтэл	44266	16.4	903.4
	Өвчлөл	191434	70.8	3,906.9

Нэгж дуудлагын өртөг зардал /төгрөг, хувиар/



➤ **УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР БЭЛТГЭСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**

Эхний хагас жилийн байдлаар 2015 оны эхний хагас жилд батлагдсан урсгал төсвөөс 18,921.7 мянган төгрөг, Улсын хөрөнгө оруулалтаар 50,0039.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэж, компьютер, тоног төхөөрөмж бэлтгэн ихэвчлэн Хан-Уул дахь салбар барилгыг ашиглалтад оруулж тохижуулахад 63 ш 68,961.6 мянган төгрөгөөр санхүүгийн чадавхаа дээшлүүлсэн.

Огноо	Нэр	Н.Б.Үнэ	Х.Н	А/Огноо	Тоо	Дүн
2015.02.27	Бичгийн ширээ/түмбочкатай/	273,900	ком	2015.02.27	2.00	547,800
2015.02.27	Дарга ширээ	834,900	ком	2015.02.27	1.00	834,900
2015.02.27	Бичгийн ширээ	150,000	ш	2015.02.27	4.00	600,000
2015.02.27	САНдал	54,900	ш	2015.02.27	10.00	549,000
2015.02.27	Компьютер DELL	935,000	ш	2015.02.27	2.00	1,870,000
2015.02.27	Дэлгэц /DELL/	253,000	ш	2015.02.27	2.00	506,000
2015.03.20	2-р хоолны тогоо	1,980,000	ш	2015.03.20	1.00	1,980,000
2015.03.25	Компьютер DELL	935,000	ш	2015.03.25	2.00	1,870,000
2015.03.25	Дэлгэц /DELL/	253,000	ш	2015.03.25	2.00	506,000
2015.03.31	Хувцасны төмөр шкаф /6 нүдтэй/	280,000	ш	2015.03.31	4.00	1,120,000
2015.03.31	Эмийн саарал төмөр шүүгээ	300,000	ш	2015.03.31	1.00	300,000
2015.04.29	Усны аппарат	299,900	ш	2015.04.29	1.00	299,900
2015.04.30	САНдал	54,900	ш	2015.04.30	5.00	274,500
2015.04.30	Хөргөгч.	509,900	ш	2015.04.30	1.00	509,900
2015.04.30	Буйдан	1,780,000	ш	2015.04.30	1.00	1,780,000
2015.04.30	Модон давхар ор	395,000	ком	2015.04.30	2.00	790,000
2015.05.28	Модон давхар ор	395,000	хос	2015.05.28	2.00	790,000
2015.05.28	Тоос сорогч	330,000	ш	2015.05.28	1.00	330,000
2015.05.28	Угаалгын машин / жижиг/	320,000	ш	2015.05.28	1.00	320,000
2015.05.29	Эмийн тавиур	180,000	хос	2015.05.29	1.00	180,000
2015.06.03	Газын плитка	177,200	ш	2015.06.03	1.00	177,200
2015.06.03	Компьютер DELL	1,078,000	ком	2015.06.03	1.00	1,078,000

2015.07.29	Эмийн тавиур	180,000	ш	2015.07.29	3.00	540,000
2015.08.03	Дефибрлятор МХ	13,873,860	ш	2015.08.03	1.00	13,873,860
2015.08.03	Зүрхний бичлэгийн аппарат HS 80GL	2,985,675	ш	2015.08.03	1.00	2,985,675
2015.08.03	ЭХО аппарат	8,870,400	ш	2015.08.03	1.00	8,870,400
2015.08.31	Хөлдөөгч	459,000	ш	2015.08.31	1.00	459,000
2015.09.30	Принтер М-2070	203,500	ш	2015.09.30	1.00	203,500
2015.11.03	Принтер М-2070	253,000	ш	2015.11.03	1.00	253,000
2015.11.03	Принтер М-2070	253,000	ш	2015.11.03	1.00	253,000
2015.11.24	Автоклаб	7,150,000	ш	2015.11.24	1.00	7,150,000
2015.11.24	Дефибрлятор / автомат/	9,680,000	ш	2015.11.24	1.00	9,680,000
2015.11.24	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат IE 1	3,080,000	ш	2015.11.24	1.00	3,080,000
2015.11.24	Эмийн шүүгээ.	2,200,000	ш	2015.11.24	2.00	4,400,000
	ДҮН				63	68,961,635

➤ **ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД**

- Автомашины үзлэг, оношлогоо, даатгал, татварт хамруулж автомашины бэлэн байдлыг бүрэн ханган ажиллалаа. Уг ажилд 5,237.1 мян төгрөгний тээврийн хэрэгслийн татвар, 810.7 мянган төгрөгний үзлэг оношлогоо, 9,954.0 мян төгрөгний даатгал нийт 16,001.8 мянган төгрөг зарцуулав.
- Байгууллагын бэлэн байдлыг хангах талаар эмнэлэг үйлчилгээг тасралтгүй хангахад ажилчдын хоол хүнсийг цалингийн нэмэгдэл хэлбэрээр олгож, автомашины зарим бага үнийн дүнтэй сэлбэг хэрэгслийг богино хугацаанд засварлан санхүүжүүлсэн.
- Байгууллагын дотоодын сургалтанд: үндсэн үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан төлөвлөгөөний дагуу 7 хоногт 1 удаа явагдсан сургалтанд бүх эмч нарыг хамруулж байгаа бөгөөд одоогийн байдлаар 552.0 мян төгрөг, БНСУ-д тус чиглэлээр байгууллагаас ажлаараа манлайлсан 2 хүнийг 2,203.4 мянган төгрөг, Герман улсын Эссен хотоос сургалт явуулахаар ирсэн 2 багшийн зардалд 2,757.6 иян төгрөг, Япон улсын түргэн тусламжийн мэргэжилтэн нагаминэ тус төвийн эмч ажилчдад 4 хоног сургалт явуулахад 1,091.9 мян төгрөг, Эрүүл мэндийн харъяа байгууллагуудын санхүүгийн чадавхийг дээшлүүлэх санхүү, бүртгэлийн сургалтанд 21 хоногт 1 хүнийг 250.0 мян төгрөг, нийтдээ 6,854.9 мян төгрөгийг дотоод сургалт, томилолтын зардалд зориулаад байна.
- Ажилчдын нийгмийн асуудлыг шийдэрлэх уралдаан тэмцээн, спорт, бусад аян, арга хэмжээ, нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал, ахмад өндөр настанд үзүүлсэн хүндэтгэлийн зардал, ажилчдын үр дүнгийн урамшуулалын зардал
 - ✓ Хаврын уламжлалт байгууллагын спартакиадад 1,150.0 мян төгрөг
 - ✓ Байгууллагын дугуйн уралдаан шагналд 100.0 мян төгрөг
 - ✓ НЭМГ-аас зохион байгуулсан спорт, уралдаан тэмцээнд 2,532.0 мян төгрөг
 - ✓ Хүүхдийг эрхийг хамгаалах өдөрт 5,745.0 мян төгрөг
 - ✓ Авто баазуудын дунд зохиогдсон уралдаан тэмцээнд 300.0 мянган төгрөг
 - ✓ Тээвэрчдийн 90 жилийн ойг тохиолдуулан зохион явуулсан тэмцээн, онол практикийн бага хурал болон уг арга хэмжээнүүдийн шагнал урамшуулалд 1,150.0 мянган төгрөг

- ✓ Цагаан сараар 190-ээд ахмад, өндөр настангуудад хүндэтгэл үзүүлж 3,089.0 мянган төгрөг, Ахмадын баярын хүндэтгэл үзүүлж мөн зардалд 9,900.0 мянган төгрөг
 - ✓ Өөрсдийн ажилчдын дээд байгууллагуудаас авсан дагалдах шагналд 2,100.0 мянган төгрөг
 - ✓ Тэтгэвэрт гарч буй ажилчдад 7,041.0 мянган төгрөг, ажилчдын буцалтгүй тусламжинд 577.5 мянган төгрөг
 - ✓ Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг, оношлогоонд хамруулсан 25,285.0 мянган төгрөг
 - ✓ Ажилчдад 1-4 улирлын ажлын үр дүнгийн урамшуулалд 219,671.6 мянган төгрөг НИЙТДЭЭ 278,641.1 МЯНГАН ТӨГРӨГ-ийг зарцуулсан.
- Хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, засварлаж ашиглалтанд оруулах, дотоод нөөц боломжоо ашиглан хөрөнгө бэлтгэх ажлын хүрээнд
 - 5.1 Салбаруудын сургалтын өрөөний даавуун бүрээстэй 27 сандал, 2 буйдан, оффисын өрөөний 2 хүлээлгийн сандал зэргийн бүрээсийг хагас савхин эдлэл болон дайвар материалууд 208,450 төгрөгөөр авч, өөрсдийн ажилчдын хүч хөдөлмөрөөр хийж ашиглалтанд оруулсан. Ингэснээр 1861,550 төгрөгийн үр ашиг, хэмнэлт үүссэн гэж үзэж байна.

№	Материалын нэр	хэмжих нэгж	тоо	нэгж үнэ	Зарцуулсан зардал
Зарцуулсан зардал					
1	Лидрин	м	34	5500	187000
2	Эмжээр	боод	2	6600	13200
3	Үдээс / кноп/	хай	2	1375	2750
4	Үдээс / кноп/	хай	2	2750	5500
	Дүн				208,450
Шинээр авахад гарах зардал					
1	Сандал	ш	27	25000	520,000
2	Хос сандал	ш	2	25000	50,000
3	Буйдан	ш	2	750,000	1500,000
	Дүн				2070,000



- а) Хан-Уул салбар шинээр ашиглалтанд орсонтой холбоотой гал тогооны 2 урт ширээ /20 хүн сууж хооллох боломжтой/, хоолны бэлтгэлийн ширээ, плитканы суурь, аяганы тавиур, бохир хураах тавиуруудыг 688130 төгрөгийн урсгал засварын материал авч өөрсдийн ажилчдын хүчээр хийж ашиглалтанд оруулав.

№	Материалын нэр	Хэм нэгж	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
Цайны газрын ширээ /2 ширхэг/ 240x120					
1	Өнгөт хавтан	ш	2	61600	123200
2	Төмөр	м	50	4120	206000
3	Электрод	боод	1	9900	9900
4	Таслагчийн ир	ш	3	4400	13200
5	Будаг шүршдэг	ш	4	2750	11000
	Дүн				363300
Цайны газрын бэлтгэлийн ширээ					
1	ДСП хавтан	ш	1	41800	41800
2	Гөлмөн төмөр	ш	1	24200	24200
	Дүн				66000
Цайны газрын аяганы тавиур, плитканы суурь, бохирын тавиур, хоолны тавиур					
1	Төмөр	м	54	3850	207900
2	Паняр	ш	2	16500	33000
3	Будаг шүршдэг	ш	4	3080	12320
4	Шруп	гр	0,3	18700	5610
	Дүн				258830
НИЙТ ГАРСАН ЗАРДАЛ					688130
ШИНЭЭР АВАХАД					
Цайны газрын ширээ /240x120/			2	500000	1000000
Бэлтгэлийн ширээ			1	150000	150000
Газан плитканы суурь ширээ			1	85000	85000
Бохирын тавиур			1	85000	85000
Хоол аяглах ширээ			1	85000	85000
Сав суулганы тавиур			1	85000	85000
НИЙТ /ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ/					1490000



Бэлтгэлийн ширээ /гөлмөн төмрөөр бүрж, төмрөөр



Цайны газрын ширээ 2 ширхэг /нийтдээ 20 хүн суух боломжтой 240x120 хэмжээтэй өнгөт хавтан, хөлийг зориулалтын төмрөөр гагнаж хийсэн/



Аяга тавга тавих ширээ /240x60 хэмжээтэй өнгөт хавтан, хөлийг зориулалтын төмрөөр гагнаж хийсэн/



Сав суулганы тавиур /хөлийг зориулалтын төмрөөр гагнаж хийсэн/ хөлийг зориулалтын төмрөөр гагнаж хийсэн



Газан плитканы суурь /60X120 хэмжээтэй өнгөт хавтан, хөлийг зориулалтын төмрөөр гагнаж хийсэн/



Бохир аяга таваг хураах ширээ /60X140 хэмжээтэй өнгөт хавтан, хөлийг зориулалтын төмрөөр гагнаж хийсэн

- Төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө бэлтгэх зардал шинэ салбарт нэмж батлагдаагүйгээс бусад 4 нэгжүүдэд шаардлагатай хөрөнгө бэлтгэх, компьютер техник хэрэгслийн хоцрогдлыг арилгах зэрэг ажлууд орхигдсон энэ үед 1,601,870 төгрөгийн хэмнэлт гаргаж үр дүнтэй ажиллалаа
 - Авто баазын сургалтын өрөөг бүрэн тохижуулахад 8 ширээ, 7 үргэлж сандал, шкаф, самбаруудыг шинээр авах боломжгүй тул 1,177,010 төгрөгийн материал авч өөрсдийн ажилчдын хүчээр хийж ашиглалтанд оруулж 1,627,880 төгрөгөөр үнэлэв.
 - Авто баазын сургалтын өрөөг материал авч тохижуулсан тооцоо


№	Материалын нэр	Хэм нэгж	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
Ширээ /8 ширхэг/ 120x60					
1	ДСПЕ	ш	4	36500	146000
2	Төмөр	м	72	3000	216000
3	Электод	боод	1	10000	10000
4	Таслагчийн ир	ш	13	700	9100
5	Будаг шүршдэг	ш	15	2800	36400
6	Точелын ир	ш	1	2000	2000
7	Хуулга	м	30	800	24000
8	Булан төмөр	ш	1	3300	3300
9	Пивор таг	ш	64	480	30720
	Дүн				477250
2 хүний сандал / 7 ширхэг / 120x25					
1	Банз	ш	17	4400	74800
2	Төмөр	м	36	3000	108000
3	Точелын ир	ш	1	2000	2000
4	Таслагчийн ир	ш	7	700	4900
5	Будаг шүршдэг	ш	10	2800	28000
6	Булан төмөр	ш	1	3300	3300
7	Пивор таг	ш	46	480	22080
	Дүн				243080
Шкаф /1 ширхэг/ 195x165x40					
1	Аргелет	ш	2	12000	24000
2	Бариул	ш	4	1800	7200
3	Нугас	ш	4	2500	10000
4	Хуулга	м	32	800	25600

	Дүн			66800
Самбар хийхэд				
1	Материалд			389880
	БҮГД			1,177,010
ШИНЭЭР АВАХАД				
1	Ширээ	8 ш	85000	680000
2	Сандал	7 ш	54000	378000
3	Шкаф /1 ширхэг/ 195x165x40	1 ш	180000	180000
4	Самбар /Амилуулах сургалт/	3 ш	21300	63900
5	Самбар /Замын хөдөлгөөний дүрэм/	2 ш	21300	42600
6	Самбар /Төрийн дуулал/	1 ш	18300	18300
7	Самбар /Жолоочийн сүлд дуу/	1 ш	18300	18300
8	Самбар /дүрмийн тэмдэглэгээ/	9 ш	26000	234000
9	Самбар /дүрмийн тэмдэглэгээ/	1 ш	12780	12780
ДҮН				1627880



Шкаф 1ш 195x165x40 /өнгөт ДСП хавтанг зүсч хийв/

Самбарууд /Төрийн дуулал, жолоочийн сүлд дуу, замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээ, хууль/





➤ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮР ДҮН, ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЛААР

Байгууллагын санхүү, НББ-ийн үйл ажиллагаанд цахим хуудсаар олон нийтэд ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, мэдээлэх, мэдээллийг иргэд, олон нийтийн оролцоог хангасан байхаар “Шилэн данс” шинээр нээж өгөгдсөн маягтын дагуу цахимаар цаг хугацаанд нь мэдээлж байна.

Шилэн дансны шалгалт хяналтыг хийлгэж бүрэн хөтөлсөн үнэлэлт авсан.

Нийслэлийн аудитын газраас 2014 оны санхүүгийн тайлан, баланст хийгдсэн хяналт шалгалтаар “Зөрчилгүй” дүн авч олон улсын НББ-ийн стандартад нийцүүлэн боловсруулан батлуулсан “НЯТТ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн дагуу санхүүгийн тайлан, балансыг гаргаж тайлагнасан “Зөрчилгүй” үнэлгээ авсан.

Ажиллагсдынхаа нийгмийн баталгааг хангаж, хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэн идэвх санаачлагатай ажиллаж байгаа танай байгууллагыг Нийгмийн даатгалын шинэ тогтолцоонд шилжсэний 20 жилийн ойг тохиолдуулан “ХАМГИЙН ОЛОН ДААТГУУЛАГЧТАЙ ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГА”-аар шалгарч ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ-өөр шагнагдсан.

Нийслэлийн төсөвт байгууллагын удирдлагатай байгуулсан “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний биелэлтийн дүнгээр өмчийн эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах, үр бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр гэрээгээр хүлээсэн үүргээ “Бүрэн хангалттай” биелүүлж “ТЭРГҮҮНИЙ ӨМЧ ЭЗЭМШИГЧ БАЙГУУЛЛАГА”-аар шалгарсан.

Төсвийн хөрөнгийн үр ашиг, дотоод нөөц боломжоо ашиглан өр төлбөрийг багасгах хэмнэгдсэн зардлаа бусад хүрэлцээгүй зардлуудад “зардлын бүлэг хоорондын шилжүүлэг” хийлгэх зэргээр зохицуулж эм, шатахууны тасалдалгүй бэлэн байдлыг ханган ажилласан.

- 2014 онд Нийслэлийн Засаг даргатай Түргэн Тусламжийн салбар пункт барих “Төслийн зураг төсөл боловсруулах-барих-шилжүүлэх онцгой эрх /концесс/-ээр хийсэн гэрээний дагуу 2,6 тэрбумын өртөгтэйгээр Хан-Уулын салбар барилгыг гүйцэтгэгч “Хүрэл-ордон” ХХК барилга угсралтын ажлыг хийж 2015 оны 02 сарын 27-ны дотор улсын комиссоор хүлээн авч үйл ажиллагаагаа явуулж байна.



Гадна фасад



Зохицуулагчийн өрөө

- Биет хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, ажиллагсдыг ажиллах таатай нөхцөл бүрдүүлэхийн тулд нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын тушаалыг үндэслэн дараах хөрөнгийг худалдан авсан болно. Үүнд:

№	Огноо	Материалын нэр	Н.Б.Үнэ	Х.Н	Тоо	Дүн	Бэлтгэн нийлүүлэгч	Тушаал шийдвэр
1	15.02.27	Компьютер DELL	935000	ш	2	1870000	Сартпланет ХХК	НӨХГ-ын 2015.03.09 өдрийн 6/1227 тоот тушаал
2	15.02.27	Дэлгэц /DELL/	253000	ш	2	506000	Грандворк интернэшнл ХХК	
3	15.03.20	2-р хоолны тогоо	1980000	ш	1	1 980 000	Тулга төхөөрөмж ХХК	
4	15.03.25	Компьютер DELL	935000	ш	2	1 870 000	Сартпланет ХХК	
5	15.03.25	Дэлгэц /DELL/	253000	ш	2	506 000	Грандворк интернэшнл ХХК	
6	15.04.29	Усны аппарат	299900	ш	1	299 900	Нэкст электроникс ХХК	
7	15.04.30	Хөргөгч.	509900	ш	1	509 900	БСБ электроникс ХХК	
8	15.05.28	Тоос сорогч	330000	ш	1	330 000	Эцэг тайж ХХК	
9	15.05.28	Угаалгын машин / жижиг/	320000	ш	1	320 000	Эцэг тайж ХХК	
10	15.06.03	Компьютер DELL	1078000	ком	1	1 078 000	Би Си Ти ХХК	
13	15.08.03	Дефибрлятор МХ	13873860	ш	1	13 873 860	Баянгол мед ХХК	
14	15.08.03	Зүрхний бичлэгийн аппарат HS 80GL	2985675	ш	1	2 985 675	Баянгол мед ХХК	

15	15.08.03	ЭХО аппарат	8870400	ш	1	8870400	Баянгол мед ХХК	
16	15.08.31	Хөлдөөгч	459000	ш	1	459000	Саммит Компьютер Технологи ХХК	НӨХГ-ын 2015.03.09 өдрийн 6/1227 тоот тушаал
17	15.09.30	Принтер М-2070	203500	ш	1	203500	Инк колор ХХК	
ДҮН						35 662 235		
2. Тавилга эд хогшил								
1	15.02.27	Бичгийн ширээ/түмбочк атай/	273900	ком	2	547800	Солонго Тамир ХХК	НӨХГ-ын 2015.03.09 өдрийн 6/1227 тоот тушаал
2	15.02.27	Дарга ширээ	834900	ком	1	834900	ДЭМТ ХХК	
3	15.02.27	Бичгийн ширээ	150000	ш	4	600000	ХАШХАН ХХК	
4	15.02.27	САНдал	54900	ш	10	549000	БСБ Трейдинг ХХК	
5	15.03.31	Хувцасны төмөр шкаф /6 нүдтэй/	280000	ш	4	1120000	ХАШХАН ХХК	
6	15.03.31	Эмийн саарал төмөр шүүгээ	300000	ш	1	300 000	ХАШХАН ХХК	
7	15.04.30	САНдал	54900	ш	5	274 500	БСБ Трейдинг ХХК	
8	15.04.30	Буйдан	1780000	ш	1	1 780 000	Эцэг тайж ХХК	
9	15.04.30	Модон давхар ор	395000	ком	2	790 000	Эцэг тайж ХХК	
10	15.05.28	Модон давхар ор	395000	хос	2	790 000	Эцэг тайж ХХК	
11	15.05.29	Эмийн тавиур	180000	хос	1	180 000	Бөжэ ХХК	
12	15.06.03	Газын плитка	177200	ш	1	177 200	Хүслийн тэмцэл ХХК	
13	15.07.29	Эмийн тавиур	170000	ш	3	510 000	Эцэг тайж ХХК	НӨХГ-ын 2015.03.09 өдрийн 6/1227 тоот тушаал
ДҮН						8453400		
НИЙТ ОРЛОГЫН ДҮН						44 115 635.0		

- 2015- 2016 оны өвлийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу Баянзүрх салбарын дулааны узелийн халаалтын 2 насос, авто баазын дулааны узелийн халаалтын 2 насосууд шинээр сольж барилгын урсгал засварыг төвийн болон салбар барилга, авто баазын барилгуудад 3,9 сая төгрөгийн зардал гарган хийсэн



Баянзүрх салбарын халаалтын насос Авто баазын халаалтын насос

- Өрөө тасалгаануудын дотор гэрэлтүүлэгт үзлэг шалгалт хийж зарим нэг шатсан гэрлийг сольсон
- Гадна бохир усны дундын шугамыг УСУГазрын мэргэжлийн хүмүүсээр 80 000 төгрөгөөр угаалгаж цэвэрлүүлсэн

6. Дотоод зохион байгуулалт арга хэмжээний хүрээнд:

- Эрүүл мэнд спортын яам Нийслэлийн Эрүүл мэндийн газар Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагуудын ассемблейн хурлыг угтан ажиллах түргэн тусламжийн үйлчилгээг зохицуулах Нийслэлийн түргэн тусламжийн захирлын 2015 оны 09 сарын 10- ны А/35 тоот тушаал гарган төлөвлөгөө гарган ажилласан. Тухайн арга хэмжээнд төрийн тусгай хамгаалалтын газрын гаргасан байршил цагийн хуваарийн дагуу шуурхай нэрсийг холбогдох утасны дагуу НЭМГ-н мэргэжилтэн Ш.Тэгшбаярт хүргүүлсэн. Цувааг угтах үдэх 5 байршил болон байнгын байрлах нэг цэг, Цонжин бодлогын цуваанд ажиллах нийт эмч 35, 9 сувилагч, 35 жолооч нийт 79 ажилтан тогтсон цагуудад хариуцлагатай ажилласан. Мөн эмнэлгийн түргэн тусламжийн 16 автомашин, 157 цагт 320 км ажилласан. Ажиллах хугацаанд 3 үйлчлүүлэгчдэд анхан шатны үзлэг хийсэн ба өөрчлөлтгүй яаралтай бус өвчлөлд зөвлөгөө өгсөн. Хуваарийн өөрчлөлт болон бусад мэдээллийг зохих шатны ажилтанд цаг тухайд мэдээлж ажилласан. Тухайн өдрүүдэд эм, эмнэлгийн хэрэгсэл болон автомашины бэлэн байдлыг бүрэн хангаж зөрчил дутагдалгүй ажилласан.
- “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд 2015 оны 08 дугаар сарын 8, 9-ны өдрүүдэд Хүй Долоон худагт “Даншиг наадам, Хүрээ цам” соёлын наадам зохион байгуулсан. Уг наадамд жолооч нар маань идэвхтэй оролцсон.
- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын ассемблейн хурлын үед давхардсан тоогоор 16 автомашин, 16 жолооч, 127 цаг, 320 километр үйлчилсэн.



- Болзолт уралдаанаар хөл бөмбөг, олс таталт, авто тээврийн хөгжлийн шинэ үе сэдэвт онол практикийн бага хурал, хамгийн хамгийн шилдэг жолооч шалгаруулсан.



- Онол практикийн бага хуралд жолооч нар идэвхтэй оролцож “Түргэн тусламжийн төвийн хөгжлийн үе шат”, “Түргэн тусламжийн төвийн тогтолцооны шинэчлэл”, “Авто тээврийн салбарын эрх зүйн шинэчлэл”, “Түргэн тусламжийн төвийн эрсдэл” сэдвүүдээр тус тус илтгэл тавьсан. Мөн нийт ажилчдын дунд хүчит бөхийн барилдаан зохион байгуулсан.



- 2015 оны 10 дүгээр сарын 14-ны өдөр нийслэлийн түргэн тусламжийн төвийн 85 жилийн ойн баярт зориулсан урлагийн үзлэгийг Улаанбаатар чуулгын хамт олонтой хамтран зохион байгуулсан.




Эмнэлгийн тусламж үйлчилгээнээс:

- 2015 онд Эрүүл мэндийн яамнаас гаргасан эмчилгээ оношилгооны стандартуудын хэрэгжилтийг тус байгууллагад мөрдүүлэхийн тулд салбар төвүүдийн ээлж хэсгүүдэд төлөвлөгөө гарган хуваарилж ажилласан. Үүний үр дүнд нийт эмч, сувилагч нарын эмчилгээ оношилгооны стандартуудын хэрэгжилт сайжирсан. Үүнд:
 - **Чихрийн шижин өвчний стандарт удирдамжийг** хэрэгжүүлэхээр Сонгинохайрхан салбарын 1 дүгээр ээлж “Чихрийн шижин өвчнөөс сэргийлье” гэсэн уриан дор төлөвлөгөө гарган ээлжийн хүрээнд сургалтын гарын авлага гарган сургалт явуулсан. Мөн салбарын 1 ба 3 дугаар ээлжийн эмч нарыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Мөн САНКТ барилгын компанитай гэрээ байгуулан урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулан тайлагнасан. Нийт 58 ажилчид үзлэгт хамрагдсан бөгөөд үзлэгээр биеийн жин өндрийн харьцаа, артерийн даралт, өлөн үеийн цусан дах сахарын хэмжээг тодорхойлж чихрийн шижин өвчний эрсдэлд хүчин зүйлс болон уг өвчнөөс урьдчилан сэргийлэх аргын талаар зөвлөгөө өгсөн.





- **Эмийн жор бичилтээр** эмч нараас сар бүр шалгалт авч хэвшсэн. Шинээр гарсан жорын стандартын талаар ээлжүүдийн нийт 45 эмчид сургалт явуулсан. 10000 ширхэг энгийн эмийн жорын маягт хэвлүүлэн нийт дуудлагын эмч нарыг тасралтгүй хангав.



- **“Тархины цус харвалт”** өвчний удирдамжийн дагуу төлөвлөгөө гарган нийт эмч нартаа Харвалтын удирдамжийн дагуу хичээл заасан.
- Баянзүрх салбарын ээлжийн эмч нараас 2015 онд 4 сард хийх ажлын асуумж аван Хэлэлцүүлж, Зонхилон тохиолдох өвчлөлөөс **“Зүрхний цочмог шигдээс “өвчний удирдамжийн** дагуу хийх жилийн төлөвлөгөөг гарган Зүрхний цочмог шигдээсээр эмч нарт илтгэл тавьсан. 2015 оны 3,4 улиралд 25 хоногийн сургалтыг тус төвийн эмч нарын дунд зүрхний цахилгаан бичлэг уншиж сургах, зүрхний өвчний зарим чухал эмгэг жамыг сургалтаар оруулж эмнэлгийн тусламж үйлчилгээг газар дээрх болон эмнэлэг хүртэлх тусламжийг стандартын дагуух эмчилгээг цаг алдалгүй хийж эмнэлэг рүү тээвэрлэх ба оношилгооны ач холбогдолтой боллоо. Сургалтыг ажлын бус цагаар өдөр бүр 10 цагаас 12 цаг 30 минут хүртэл 2 цаг 30 минутаар явуулсан. Нийт 58 цаг 30 минутын сургалт орсон. Сургалтад 3 ээлжийн 49 эмч орж ирснээс 41 эмч буюу 83,6% нь тасралтгүй сурч дүүргэлээ.



- **Осол гэмтлийн үед** газар дээрх болон эмнэлэг хүртэлх тусламж үйлчилгээний чанар сайжирсан.



Осол гэмтлийн дуудлагын судалгаа хийж, машины чиг шалгах ажиллагаа 100% биелэгдэн ажилласан. Энэ шалгалтын үеэр 10 машин шалгуулж жолооч нар алдаа зөрчлөө арилгасан болно.



- Тухайн ажилд ээлжийн эмч, жолооч нар идэвхтэй оролцож чиггүй байгаа машин бөгөөд, мөн хүүхдийн насанд тохирсон чиг байхгүй байгааг олж тогтоолоо. Цаашид төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлыг цаг тухайд нь хийх болно.



- “Тогонд цохиулах үеийн арга хэмжээ, түлэгдэлт, түлэгдэлтийн зэргийг үнэлэх хичээл зааж дүгнэлт хийлээ.



- Сонгино хайрхан салбарын 3-р ээлжийн чанарын баг болон чанарын албанаас хамтран зохион байгуулсан **эх барихын удирдамжийн** хэрэгжилтийг сайжруулахаар зохион байгуулагдан салбар нэгжүүдийг оролцуулсан 8 багийн дунд мэтгэлцээн явуулсан.



- **Түгээмэл үйлдлийн стандартуудын хэрэгжилт:** Нийт дуудлагаас осол гэмтлийн дуудлага өмнөх оны мөн үеэс 2.8%- иар нэмэгдсэн бөгөөд осол гэмтлийн үеийн газар дээр үзүүлэх тусламж үйлчилгээнээс шархны анхны цэгцэлгээ ба боолт хийх тусламж 1.4%-иар нэмэгдсэн байна. Зүрх судас болон мэдрэлийн хурц эмгэгийн дуудлага 1.6%- иар өсөж, хүчилтөрөгч маскаар болон гуурсаар өсөлт 1.0 %- иар өссөн үзүүлэлттэй байна. Бусад өвчлөл өмнөх оноос 11.3%- иар нэмэгдэж газар дээрх болон эмнэлэг хүртэлх тусламж үйлчилгээ сайжирч, эмийн болон эмийн бус зөвлөгөөг өгч ажилласнаар шаардлагагүй эмнэлэг хүргэлт 8%-иар, тарианы хатгалтын тоо 1%-иар тус тус буурсан байна.




- “Тарилгын стандарт”-н гардан үйлдлээр ижил мэргэжилтний кейс сугалуулан хяналт хийв.

- **Цэвэрлэгээний удирдамжийг хэрэгжүүлэхээр доорх ажлуудыг хийсэн.** Сонгинохайрхан салбарын ээлжүүд хуваарийн дагуу гадна, дотно цэвэрлэгээг 14 хоног бүр цэвэрлэж хэвшсэн.




- 2015 оны 6 сарын 04 өдөр “Халдвар хяналт” 186,187 тоот тушаалын дагуу үйлчлэгч нарт сургалт сурталчилгаа явуулж зааварчилгаа өгсөн. Мөн цаашид сард нэг удаа уулзалт зохион байгуулж гарсан алдаа зөрчил болон шинэ санаачлагатай ажиллахаар болсон.




Нэг удаагийн хамгаалах хэрэгсэл 80 ширхэг, нэг удаагийн бээлий 2000 ширхэг, маск 2011 ширхэг, улавч 2500 ширхэг, нэг удаагийн ариутгасан бээлий 200 ширхэг, жавелион 120 ширхэг хлорсепт 600 таблетка нөөцөнд байна.

- **Чанарын албанаас** 33 их эмчийн 330 дуудлагын хуудсанд 7 төрлийн өвчлөлийн тусламж үйлчилгээнд стандарт, удирдамжийн хэрэгжилт ямар чанарын үзүүлэлттэй байгааг ижил мэргэжилтний үзлэгийн үзүүлэлтээр дүгнэж үр дүнг тооцож ажиллаа. Үүний үр дүнд эмч нарын дуудлагад үзүүлж буй тусламж үйлчилгээ стандарт удирдамжийн дагуу үзүүлэхэд чанарын ахицыг үзүүлж байна. Доорх хүснэгтээр үзүүлэхэд:



Цаашид тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, онош зөв тодорхой товчлохгүй гаргацтай бичих, эм тариа оношийн дагуу зөв зохистой хэрэглэх, гарсан алдаа зөрчлийнхөө дагуу мэдлэг боловсролоо дээшлүүлэх шаардлагатай байна.

Осол гэмтлийн дуудлагын 2 эмчийн нийт 20 картанд ижил мэргэжилтний үзлэг хийсэн.




Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны дуудлагын 9 эмчийн 90 картанд ижил

Үзүүлэлт	Онош алдаатай, товчилж бичсэн	Оношийн үндэслэл зөрсөн	Зовиур, өвчний түүх гүйцэд бичээгүй	Зөвлөгөө өгсөн байдал	Эмнэлэгт хүргэсэн цаг бичээгүй	Өвчин эхэлсэн хугацаа бичээгүй
Тоо	22	24	47	43	7	12
Хувь	24.4%	26.6%	52.2%	47.7%	7.7%	13.3%

мэргэжилтний үзлэг хийсэн.

Дуудлагын 5 эмчийн зүрх судасны өвчлөлийн 50 картанд ижил мэргэжилтний үзлэг хийсэн үзлэгээр илэрсэн зөрчлийг нэгтгэн гаргав.




Төрөх эмэгтэйчүүдийн дуудлагатай холбоотой 8 эмчийн 80 картанд ижил мэргэжилтний үзлэг хийсэн.

Үзүүлэлт	Онош алдаатай, товчилж бичсэн	Оношийн үндэслэл зөрсөн	Зовиур, өвчний түүх гүйцэд бичээгүй	Зөвлөгөө өгсөн байдал	Эмнэлэгт хүргэсэн цаг бичээгүй	Өвчин эхэлсэн хугацаа бичээгүй	Ерөнхий үзлэг
Тоо	16	29	33	26	10	24	16
Хувь	20%	36.2%	41.2%	32.5%	1.2%	30%	20%

Мэдрэлийн өвчлөлийн дуудлагатай холбоотой 5 эмчийн 50 картанд ижил мэргэжилтний үзлэг хийсэн.



2 эмчийн амьсгалын замын өвчлөлтэй холбоотой дуудлагын 20 картанд ижил мэргэжилтний үзлэг хийсэн



- Чанарын сургалтыг нийт 77 удаа зохион явуулсан. Ажлын байран дахь эмнэлэг үйлчилгээ болон сувилахуйн тусламж үйлчилгээний мэргэжлийн сургалтыг долоо хоногт нэг удаа тогтмол зохион байгуулж байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар 24 өдөр 15 сэдвээр сургалт явуулсан байна.
- 2015 оны 06 дугаар сарын 12-ны өдөр чанарын албанаас “Сэтгэлийн хөг” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан “ Эмч, эмнэлгийн ажилтнуудын эмнэлзүйн болон ёс зүйн алдаа, зөрчлөөс сэргийлэх “ 1.5 кредитийн сургалтад 36 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд хамрагдсан. Чанарын албанаас зохион байгуулсан ёс зүйн 1.5 кредитийн сургалтад байгууллагын нийт 120 их эмчийг хамруулж сургалт орсны үр дүнд ёс зүйтэй холбоотой гомдол санал буурсан.
- Баянзүрх салбарын их эмч З.Баярсайхан жирэмсэн эхчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах сарын аяны удирдамж гарган төлөвлөгөөний дагуу ажиллан үр дүнг тооцсон.



- **Авто баазад** нийт 27 удаа сургалт явуулсан. Үүнээс амилуулах, осол гэмтлийн тусламж, халдвар хамгаалал, тоног төхөөрөмжийн сургалт 12, хаягийн сургалт 4, дүрмийн сургалт 7, алдаан дээр суурилсан сургалт 4 удаа тус тус явуулсны үр дүнд газар дээрх болон эмнэлэг хүртэлх тусламжид жолооч нарын оролцоо сайжирч, тусламж үйлчилгээний чанарт ахиц гарч байна.
- Дээрх сургалтуудыг явуулснаар автомашины тоног төхөөрөмжийн ашиглалт сайжирч, хаяг олохгүй хайх үргүй зардал буурсан.



- **Эмийн сургалт:** 2015 оны 2-р сард Ээлжийн их эмч Л.Оньгэрэл байгууллагын эмч, сувилагч нарт “Нестабильная стенокардия” сэдвээр сургалт зохион байгуулан явуулсан. Моносфарм Лек пүүстэй хамтран шинээр цус тогтоох Дицинон 250 мг/2мл эмийн бэлдмэлийг яаралтай тусламжийн цүнхэнд шинээр оруулан нийт 120 эмч нарт эмийн мэдээлэл хийж танилцуулав.
- Цахиур төмөр байгууллагаас шинэ эмийн мэдээлэл хийж нийт 100 эмч 1 кредитийн сургалт хийсэн. 4 дүгээр сарын 08-09-ний өдрүүдэд Чингэлтэй дүүргийн 12-р хороо Нарантуул-2 худалдааны төвийн ажилчид, худалдаа эрхлэгчид, үйлчлүүлэгч иргэдийн дунд зохион байгуулсан өдөрлөг, эмийн зохистой хэрэглээ эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгээр 2 дугаар ээлжийн зүрх судас, дотоод шүүрэл, мэдрэл, дотрын их эмч нар сувилагч нар хамтран ажилласан.
- 2015 оны 5 дугаар сарын 20-нд “Эмийн зохистой хэрэглээ” сэдвээр Батхуяг багшаар нийт 40 эмч сувилагчид хичээл орсон.
- Судалгааны үр дүнд: Салбарын 18 эмчээс байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад 100%, /Амилуулах суурь тусламж 100%, ХӨЦМ –н сургалтанд 60%, резидентийн сургалтад хамрагдан суралцаж байгаа нь 40% байна. Гадаадын яаралтай тусламжийн сургалтад 1 эмч хамрагдсан байна. Үүнээс харахад ХУС-н 3 ээлжийн нийт эмч нарын 80% нь нарийн мэргэжлийн сургалтад 60%, дотоодын сургалтад 100% хамрагдсан байна. Гадаадын яаралтай тусламжийн сургалтад 18 эмчээс 1 эмч хамрагдсан байна.
- **Эрдэм шинжилгээ судалгаа:**
МУИС-ийн Хэрэглээний математикийн дээд сургуулийн багш Б.Жамъяншаравын хамт 2010 оны 6 дугаар сараас 2014 он хүртэлх зонхилох 12 дуудлагын өдөр бүрийн тоонд судалгаа хийгдэж байна. Урьдчилсан байдлаар Улаанбаатар хотод тархинд цус харвах, цусны даралт ихсэх өвчин, бусдад хорлогдсон, гуурсан хоолойн багтраа өвчний дуудлага жилийн тодорхой үед ихсэж байгаа урьдчилсан үр дүн гарч байна. Эрдэм шинжилгээний өгүүллэг 11 хэвлүүлж Монголын анагаахын ухааны академи

байгуулагдсаны 10 жилийн ойн эрдэм шинжилгээний хуралд “XX зууны эхэн үед монголд ажиллаж байсан гаднын эмч нар” илтгэл тавив.

- Нөлөөлөх хүчин зүйл болох тамхины хор уршигийг таниулах, хүүхдүүдийг дам тамхидалтаас сэргийлэх талаар нийт 342 ажилтанд сургалт явуулж зөвлөгөө өгч гарын авлага 680 ш тарааж “Дэлхийн тамхигүй өдрөөр БЗД, СХД, Төвийн салбар, автобаазад өдөрлөг зохион байгуулж 2015 оны 5 сарын 30 нд Байгууллагын чийрэгжүүлэгч эмч С.Угтахбаяр 40 минутын сургалт явуулж ажилчдын хүүхдүүдийн дунд “Архи, тамхины сэдэвт гар зураг, зохион бичлэгийн уралдаан зарлаж дүгнэж шалгаруулсан. Уралдаанд нийт 15 материал ирснийг сургуулийн ахлах анги, бага анги, цэцэрлэгийн насны гэсэн 3 ангиллаар эхний 3 байр эзлүүлж хүүхэд бүрд өргөмжлөл, бэлэг бичгийн хэрэгсэл өгсөн. Хүүхдүүдийн уралдаанд ирүүлсэн материалаар үзэсгэлэн гаргаж мөн тамхины сэдэвтэй блокат санамж, зөвлөмж, гарын авлага 750 ширхэгийг тараасан.



- Ажлын байр болох машинд тамхи татсан жолоочийг торгуулийн арга хэмжээ авах тамхинаас бүр мөсөн татгалзан гарч чадсан 31 ажилчинд талархал дэвшүүлж туршлагыг нэвтрүүлж татгалзаж гарахаар гэрээ хийсэн 8 ажилтныг хянан ажиллаж байна. “Тамхины хэрэглээ, дам тамхидалтын хор нөлөө”-ний талаарх Сургалтад нийт 542 иргэн / хүүхэд / хамрагдсан байна. Сурталчилгаанд тамхинаас гаргах тусламж үйлчилгээнд 1398 хүн хамрагдсан.


7. Байгууллагын тохижилт үйлчилгээг сайжруулах чиглэлээр

Нийслэлийн засаг даргын 2015 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/304 дүгээр захирамжийн дагуу тус төвийн захирлын 2015 оны 05 сарын 01-ны өдрийн А/14 тоот ажлын хэсэг байгуулах тухай тушаал гарган төв болон салбаруудын хэмжээнд болзолт уралдааны ажлын төлөвлөгөөг 36 зүйлтэйгээр гарган ажиллаж биелэлт 100 хувь байлаа. Тухайн аяны хүрээнд хийсэн ажил, явц, үр дүн, суурь судалгааг үзүүлэлтүүдийн дагуу гаргасан. Тус аяны хүрээнд нийт 164.767.455 сая төгрөг зарцуулсан Үүнд:

- Түргэн тусламжийн авто баазын гадна зүлэгний төмөр хашаа, гадна гүйдэг хаалга, замын хашлагыг будаж өнгө үзэмжийг сайжруулахад нийт 242.000 төгрөг зарцуулж тухайн орчны өнгө үзэмж сайжирсан.



- Баянзүрх салбарын хийх ажлын төлөвлөгөөний дагуу 2015 оны 9 дүгээр сар 17-ны өдөр 4,557,600 сая төгрөгийн зардал бүхий 253,2 м2 талбайг хатуу хучилттай болгосон. Ингэснээр үйлчилгээний соёлыг сайжруулж, гадна орчны тоосжилт, цэвэр, тухтай орчин бүрдсэн.



Өмнө нь



Дараа нь

№	Нэр төрөл	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Ширээ	50000	1	50000
2	Сандал	35000	2	70000
3	Хогийн сав	25000	1	25000
4	Нийт дүн			145000



- Авто баазын гадна зорчих хэсгийн эвдэрсэн талбай мөн гараж доторх талбай, засварын цехийн зам талбайг цементлэн засварлахад нийт 160.000 төгрөг зарцуулснаар гадна талбайн үзэмж сайжирч автомашины эвдрэл гэмтэл багассан.



- Салбарын гадна хойд талбайд 5-р сард Түргэний голоос ургаж буй 1 наст чацаргана, долоогоно, нохойн хошуу, улиас, 1 ширхэг нь 5000 төгрөг * Нийт 21 ширхэг 105,000 төгрөгийн өртөг бүхий модыг авчирч, 0,5тн хар шороо 175,000 төгрөг, хагас машин элс 30.000 төгрөгийн зардлаар авчирч MNS5973:2009 стандартын дагуу тарьснаар гадна ногоон байгууламж сайжирсан.



- Хан-уул салбар нь талбайн хэмжээгээр хүрээлсэн хээтэй төмөр хашаа 531 м² хашааг 198.000 төгрөгөөр хийсэн. Явган хүн, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, тэргэнцэртэй үйлчлүүлэгчдэд зориулсан замтай. Үүний үр дүнд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж нэмэгдсэн.



- Хан-Уул салбарын гадна хаалганы орох хэсэгт 55000 төгрөгний өртөгтэй чулуун зам төрөл бүрийн мод тарьж зүлэгжүүлснээр орчны цэвэр байдал бүрдэж шороо тоосжилт буурч зам талбай эмх цэгцтэй болсон.



- Хог хаягдлын менежментийг нэвтрүүлж, шаардагдах битүүмжил, хамгаалалтыг сайжруулахад дараах ажлуудыг хийлээ.
- Гадна талбайн зэрлэг болон хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, байшингийн булан тохойн шигсэн шороо, машины гараж ордог хэсгийн хог /5м³/ цэвэрлэснээр эрүүл, аюулгүй, ажлын цэвэр орчин бүрдсэн.



Орчны тохижилт, ногоон байгууламжийн чиглэлээр:

Гадна тайлбайд иргэдийн болон эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын тав тухтай амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэхэд зориулан орчин үеийн шаардлагад нийцсэн ширээ сандал хогийн сав болон ногоон байгууламж бүхий цэцэрлэгжилт тохижилтийн ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: 18 ширхэг шар хуас мод, 5 ширхэг үхрийн нүдний бут, чацарганы 3 бут, 12 ширхэг цэцгийн мандал /5 төрлийн цэцэгтэй/ хийж тохижуулж. Байгууллагын гадна талбайг зүлэгжүүлж цэцэг мод тарьснаар өнгө үзэмж сайжран эко орчинг бүрдүүлсэн.

Зарцуулсан өртөг нь :

№	Нэр төрөл	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Шар хаус мод	2500	18	45000
2	Үхрийн нүдний бут	2500	5	12500
3	Чацарганы бут	2500	3	7500
4	Цэцгийн үр	1500	15	22500
5	Цэцгийн мандал	3500	12	42000
	Нийт дүн			129500

Тохижуулахын өмнөх зураг



Мод зүлэгжүүлэлт хийж буй үеийн зураг



12 ширхэг цэцгийн мандал хийж 5 төрлийн цэцэг тарьсан.



Үхрийн нүдний бут тарьж буй зураг



- Авто баазын жолооч, ажилчдын сургалтын орчинг сайжруулах үүднээс автобаазын сургалтын танхимыг тохижуулж байна. Үүнд: ширээ сандал, лавлагааны сан, автомашины тоног төхөөрөмж байршуулах тавиур хийсэн.

- Сургалтын танхимыг тохижуулснаар жолооч нар ажлаас буугаад сургагч багш нараар удирдуулан дотооддоо сургалт явуулах боломжтой болно.



- Байгууллагын сургалтын танхимын сандалд арьсан бүрээс хийсэн. Жолооч нартай хамтран эсгэж, оёж нийт 30-40 ширхэг сандал бүрсэн.



Хяналтын камерын системийн зохион байгуулалт:

- Гадна талбай, дотор орчны шаардлагатай хэсгийг хянах зорилгоор гадна талд хяналтын 2 камер, гараж дотор 14 хяналтын камерын суурилуулсан. Дотоод хяналтын камер нь 24 цагийн бичлэг хийгдэж, нийт 48 хоног хадгалагдах сервертэй. Ингэснээр дотоод хяналт сайжирч, ажилчдын ажиллах тухтай орчин нөхцөл бүрдэж байна.



- Гадна болон дотор талд эмнэлгийн байрыг байнга хянах зорилгоор камерийн системийг тавьж байршуулсан байгаа. Нийт 8 газар камер байршуулсан байгаа. Үүнд : гадна талд 2 ш, дотор талд давхар бүр камертай болсон.



- Баянзүрх салбарын гадна талбай, дотор орчны шаардлагатай хэсгийг хянах зорилгоор гадна талд хяналтын 2 камер, гараж дотор 1, 2-р давхарт 1 хяналтын камерын тус тус суурилуулсан. Хяналтын камер нь 24 цагийн бичлэг хийгдэж, нийт 48 хоног хадгалагдах сервертэй. Ингэснээр дотоод хяналт сайжирч, ажилчдын аюулгүй орчин нөхцөл бүрдсэн.

- Хан-уул салбарын гараж болон давхруудад хяналтын камер байрлуулж гадна болон дотор орчны шаардлагатай хэсгийг байнга хянаж байна.



- Сонгинохайрхан салбар нь эдэлбэр газартаа авто машины зогсоолын ховхорсон хэсгийг засаж 10 машин зогсох талбайг өөрсдийн нөөц бололцоогоор шийдвэрлэсэн. Үүнд зориулан 15м³ хайрга асгаж талбайг засаж тохижуулсан. 100.000 төгрөг зарцуулсан.



- Баянзүрх салбарын ажлын төлөвлөгөөний дагуу салбарын зүүн талын хуучин хашааг буулган цэвэрлэж нийт 33м2 м * 396000 мянган төгрөгийн өртөг бүхий хашааг шинээр хийж, будаж сайжруулсан. Ингэснээр Баянзүрх салбарын өнгө үзэмж сайжирч, иргэдийн ая тухтай орчинд



Өмнөх нь



Дараа нь




Төв, авто бааз болон салбаруудад дотоод тохижилтын ажлууд төлөвлөгөөний дагуу бүрэн хийгдсэн.

- Баянзүрх салбарт тасалгааны 95.000 төгрөгийн 21 төрлийн таримал цэцэг үрслүүлэн суулгаж цэцэгжүүлэлт хийсэн. Ингэснээр эко орчин бүрдсэн.



- Баянзүрх салбарын тохижилтыг сайжруулах зорилгоор 1 давхрын коридорын хананд 90см*70 см-ийн 315,000 төгрөгийн өртөг бүхий 21 ширхэг “Алдартай хүмүүсийн ишлэл”- бүхий самбарыг: ажилчдын ажиллах эрч хүч, урам зоригийг нэмэгдүүлэх зорилгоор хийн байрлуулж өнгө үзэмжийг сайжруулсан.




өмнөх

дараах

- Баянзүрх салбарын тохижилтыг сайжруулах зорилгоор: Эмч нарын дуудлагын карт бичилтийн өрөөнд 3 хос буйдан байрлуулсан. Ингэснээр тав тухыг нэмэгдэж эмч нарын өрөөний тохижилт сайжирсан.
- Тасалгааны 20 төрлийн цэцгийг 95.000 төгрөгөөр худалдан авч үрслүүлэн эмийн сан, цайны газар, үзлэгийн өрөө, сургалтын өрөө, угаалга, зохицуулагчийн өрөөнд байрлуулснаар өнгө үзэмж нэмэгдэн орчны тохижилт сайжирсан.
- Сонгионо хайрхан салбарын өрөө тасалгааг цэцэгжүүлэх зорилгоор 25 ширхэг цэцэг үрслүүлж суулгасан. Ингэснээр өрөө тасалгааны өнгө үзэмж сайжирсан.

Өрөө тасалгааны цэцэгжүүлэлтийн зураг




- Зохицуулагчийн өрөөний хулдаасыг солиулсан. Ингэснээр өрөө тасалгааны өнгө үзэмж сайжирч ая тухтай орчин бүрдсэн. Үүнд 20 метр хулдаас 2 ширхэг цавуу нийт 180000 төгрөг зарцуулсан.



Өмнө нь

Дараа нь

- Зохицуулагчийн өрөө, эмч нарын өрөөний хооронд цонх гаргаж хяналт тавих боломж бүрдсэн . Үүнд: 120000 төгрөг зарцуулсан.



- Байгууллагын үйлчилгээний соёлыг сайжруулах зорилгоор эмч нарын хувцас угаах угаалгын машин, индүү, хатаах хатаагч, шал угаах тэргэнцэр авч ажил үйлчилгээндээ ашиглаж байна. Ингэснээр угаагч үйлчлэгч нарын ажлын бүтээмж сайжирсан.



Үүнд зарцуулсан дүн

№	Нэр төрөл	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт дүн
1	Хатаагч	35000 төг	1	35000 төг
2	Шал угаах тэргэнцэр	60000 төг	1	60000төг
3	Шал угаах хувин алчууртай	45000 төг	1	45000 төг
4	Шүүр	15000 төг	1	15000 төг
5	Угаалгын машин	250000 төг	1	250000 төг
6	индүү	45000 төг	1	45000 төг
7	Нийт дүн			450000 төг

- Хан-Уул салбарын ажилчдын хувцас солих өрөөг дараах байдлаар тохижуулсан. Үүнд: хувцасны шкаф 24 ширхэг буюу төгрөг, цаг 1 ширхэг буюу 8000 төгрөг, хувцас солих хөшигтэй хаалт 1 ширхэг буюу 27000 төгрөг, хогийн сав 1 ширхэг буюу төгрөг, гутлын шкаф 50000 төгрөг, сандал 2 ширхэг буюу төгрөгөөр тохижуулсан. Үүний үр дүнд ажилчдын ажиллах идэвх нэмэгдсэн:



- Шатны хажуу хэсэгт цэцгийн тавиур 1 ширхэг буюу 70000 төгрөг, таримал цэцэг 9 ширхэг буюу 45.000 төгрөгөөр тохижуулсан. Үүний үр дүнд байгууллагын дотоод өнгө үзэмж нэмэгдсэн.





➤ Төвдийн Од-сэр Ринбүчийн хандиваар “Иог, бясалгалын өрөө”-г дараах байдлаар тохижуулснаар ажилчдын алжаал тайлах, стрессээс ангижрах таатай орчин бүрдсэн.



➤ Сонгинохайрхан салбарын өрөөнүүдийн хана таазыг эмульсдэж тосон будгаар ханыг нь будаж өрөө тасалгааны өнгө үзэмжийг сайжруулсан. Ингэснээр эмч , ажилчдын ая тухтай ажиллах нөхцөл бүрдсэн. Үүнд:1.300.000 төгрөг зарцуулсан.



➤ Эмч нарын амралтын өрөөнд диван ор, буйдан авч тохижуулсан. Ингэснээр эмч нарын ажлын байранд дахь ая тухтай амрах нөхцөл бүрдсэн. Үүнд 250.000 төгрөг зарцуулсан



➤ Эмч, жолооч нарын амралтын өрөөний орны гудасыг сольж шинэчилж, шинээр дэр 10 ширхэг дэр хийсэн. Ингэснээр эмч, ажилчдын ажлын дахь байранд ая тухтай амрах нөхцөл бүрдсэн.


Үүнд зарцуулсан үнэ

№	Нэр төрөл	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт дүн
1	Гудас	15000 төг	4	60000 төг
2	Дэр	3000 төг	12	36000 төг
3	Нийт дүн			96000 төг

➤ Эмч нарын ажлын байрыг сайжруулах зорилготой сургалтын өрөөг тохижуулав. Ингэснээр эмч нарын суралцах чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл бололцоог хангасан гэж үзэж байна.



Өмнө нь



Дараа нь

Сургалтын өрөөнд зарцуулсан төсөв

№	Нэр төрөл	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Номын тавиур	150000	1	150000төг
2	Хурлын ширээ	120000 төг	1	120000 төг
3	Индэр	45000 төг	1	45000 төг
4	Самбар	60000 төг	1	60000 төг
5	Сандал	25000 төг	10ш	250000 төг

6	Цаг	15000 төг	1ш	15000 төг
7	Компьютер ком	1300000 төг	1 ком	1300000 төг
8	Нийт дүн			1940000 төг



➤ Эмч ажилчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд болон мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд зориулан 8500 ш орчим номын сан бүрдүүлсэн. Ингэснээр эмч, ажилчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, мэдлэг боловсролоо дээшлүүлэх нөхцөл бүрдсэн.



➤ Авто баазад чийрэгжүүлэх танхимыг тохижуулснаар ажилчид цайны цагаар 1 цагийн дасгал хийж гурван сарын хугацаанд нийт 52кг жин хассан. Байгууллагын ажилтнуудын чийрэгжүүлэх танхимд ажилчид чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх нөхцлийг бүрдүүлэн 1.869.000 төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч тохижуулсан.

➤ Хан-Уул салбарын туслах ажилтны өрөөг дараах байдлаар тохижуулж байна. Үүнд: Ширээ 1 ширхэг буюу 20000 төгрөг, сандал 2 ширхэг буюу 90000 төгрөг, жаазтай зураг 1 ширхэг буюу 35000 төгрөг, сандал 2 ширхэг буюу төгрөг, савтай цэцэг 2 ширхэг буюу 8000 төгрөг, хогийн сав 1 ширхэг буюу 21000 төгрөг, өлгүүр 1 ширхэг буюу 31000 төгрөг, гутлын тавиур 1 ширхэг буюу 45000 төгрөг, ор 1 ширхэг буюу 80000 төгрөг, ус буцалгагч 1 ширхэг буюу 30000 төгрөгөөр тохижуулсан.



➤ Эмч, жолооч нарын амралтын өрөөнд хос модон ор 4 ширхэг буюу 1,580,000 төгрөг, гудас 8 ширхэг буюу 153,200 төгрөг, бүтээлэг 8 ширхэг буюу 224,600 төгрөг, хогийн хувин 2 ширхэг буюу 45,800 төгрөг, цаг 1 ширхэг буюу 8000 төгрөгөөр тохижуулсан. Үүний үр дүнд ажилчдын ажлын байрны тав тух нэмэгдэж, сэтгэл ханамж нэмэгдсэн.


➤ Баянзүрх салбарын хэмжээнд ажилчдын ажиллах эрч хүч, урам зориг, бүтээлч санаачлалыг нэмэгдүүлэх, орчны тохижилтыг сайжруулах зорилгоор 7 хоногийн ажлын 5 өдрийг тус тусад нь өөр өөрийн өнгө аясыг илэрхийлсэн нэртэй болгон өөрчилж, стресс менежментийг сайжруулсан.



Даваа гариг “Инээмсэглэх өдөр”



Мягмар гариг “Талархалын өдөр”



Лхагва гариг “Ухаарлын өдөр” Пүрэв гариг “Бахархалын өдөр” Баасан гариг “Хайрлан энэрэх өдөр”

Ингэснээр 7 хоногийн ажлын 5 өдөр, өөр өөрийн өнгө төрхийг илэрхийлж, ажилчдын ажлын байрны стресс тайлах менежментийг сайжруулах, үйлчлүүлэгчидтэй харьцах харьцаа хандлага сайжрах, мэргэжил нэгт нөхдөө хүндэтгэн харьцах, зэрэг эмч, ажилчдын харьцаа хандлага, ёс зүйг сайжруулах шинэлэг ажил болсон.

- 2015 оны 9 дүгээр сарын 14-нд Баянзүрх салбарын тохижилтыг сайжруулах зорилгоор 1 давхрын коридорын хананд 90см*70 см-ийн 315,000 төгрөгийн өртөг бүхий 21 ширхэг “Алдартай хүмүүсийн ишлэл” бүхий самбарыг байршуулснаар ажилчдын ажиллах эрч хүч, урам зоригийг нэмэгдүүлсэн. Ингэснээр ажлын байрны стресс менежмент сайжирч, ажилчдын харьцаа хандлага сайжирч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.



Өмнөх



Дараах



- Сонгинохайрхан салбар нь тохижилтын аяны явцын үнэлгээгээр **ТОХИЖИЛТ САЙТАЙ ЦЭМЦГЭР БАЙГУУЛЛАГА** болж смайл авсан.

- Эмч, эмнэлгийн ажиллагсдад ажлын хувцасны захиалгыг “ Би Икс Ти “ ХХК-тай гэрээ хийж, инженер техникийн ажиллагсдад 70 хос, эмч халад 25 ширхэг, эмч сувилагчдын ажлын нимгэн өмд, цамц 87 хос, эмч нарын зуны хослол 80 ширхэг тус тусыг захиалгаар оёулсан. Нийт өртөг нь төгрөг 13.811.500 төгрөг болсон.

8. Дотоодын хяналт, үнэлгээний ажлууд

- Нийслэлийн түргэн тусламжийн төв нь 2015 онд Эрүүл мэндийн сайдын 2014 оны 01 сарын 13-ны өдрийн Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны аргачлал батлах тухай 13 тоот тушаалын дагуу 202 эмч, эмнэлгийн ажилтнууд, Баянзүрх, Сонгинохайрхан салбараар үйлчлүүлсэн 449 хэрэглэгчдийг хамруулан улирал бүр сэтгэл ханамжийн судалгаа авч, статистик боловсруулалтыг excel программыг ашиглан хийв. Нийт 651 хэрэглэгч хамрагдсан ба эмнэлгийн ажиллагсдын 55,6% нь судалгаанд хамрагдлаа.



Үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа.

- Эмч, эмнэлгийн ажиллагсдын сэтгэл ханамжийн судалгаанд 128 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 74 жолооч хамрагдсан. Нийт 202 буюу ажиллагсдын 55,6% эзэлж байна.

➤ Дэмжлэгт удирдлага, хүний нөөцийн хөгжих боломж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, байгууллагын соёл, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал ажлын байрны аюулгүй, дэмжлэгт орчин гэсэн 6 бүлэг 59 асуултаар судалгаа авсан. Ерөнхий сэтгэл ханамж 95% эерэг байна.

Мөн судалгаанд оролцогчдын 71,2%, эмэгтэй, 59% нь 35 хүртэлх насныхан, 68,3% нь тус байгууллагад 1-5 жил ажиллаж байна.

1. Дэмжлэгт удирдлага 84.6% нь эерэг
2. Хүний нөөцийн хөгжих боломжийг 94,9% нь эерэг
3. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёлд 97,8% нь эерэг
4. Байгууллагын соёлыг 91,5% нь эерэг
5. Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд 96,0% нь эерэг
6. Ажлын байрны аюулгүй, дэмжлэгт орчинг 92,8% эерэг гэж үнэлсэн байна.



Судалгаанд оролцогчид нь байгууллагаас дараах дэмжлэгийг хүсэж байна:

1. Ажлын хувцас биеийн хэмжээнд тохируулж хийх.
2. Ээлжийн ахлагч, зохицуулагч нарыг сэлгэж ажиллуулах, ажлыг сайжруулах

3. Машины дугуй, бусад сэлбэг хангалтгүй байна.
4. Жолооч нарын ажлын ачааллыг багасгах, цалин нэмэх
5. Үйлдвэрчний эвлэл ажиллахгүй байна.
6. Ажлын хувцас угаалгах .
7. Эрүүл ахуй, халдвар хамгааллын үүднээс жолооч нарт нэг удаагийн шингэн нэвтэрдэггүй халад олгож байх
8. Ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг хугацаанд нь, хүрэлцэхүйц хэмжээгээр олгож байх
9. Эмч, жолооч нарын амралтын өрөөг тохижуулах, гудас бүтээлгийг шинэчлэх
10. Цалингийн тооцооны хуудсаа авч байх (олон санал)
11. Ээлжийн ахлагч, зохицуулагч нараас хаягийн талаарх мэдлэгийн шалгалт авах
12. Машины халдваргүйтгэл, ариутгалд халдвар судлаач тогтмол хяналт хийх
13. Орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх
14. Ажлын дараа усанд орох боломжоор хангах
15. Карт бичих компьютер хүрэлцээгүй удаж байна. Картаа хугацаанд нь бүрэн бичих нөхцөлөөр хангах шаардлагатай байна. (олон санал)
16. Эм, тарианы хангалт муу байна.
17. Хувцасны загвар шинэчлэх, өнгийг өөрчлөх ('пицца зөөгч, шатахуун түгээгч, цахилгаанчин нартай андуурч байна.)
18. Хувцасны шүүгээтэй болох
19. Санал бодлоо илэрхийлэх үед дарамтлахгүй байх
20. Яаралтай бус дуудлагын тоог бууруулахад чиглэсэн арга хэмжээ авах
21. Шагнал, урамшуулал ил тод байх
22. Дуудлагад явдаг машины тоог нэмэх

Талархал

1. Сонгинохайрхан салбарын эмч нар амралтын өрөөг тохижуулж гудас,дэр авч өгсөнд баярлалаа.
2. Ээлжийн эмч нартаа баярлаж байна.
3. Удирдлага, хамт олондоо талархаж байна
4. Байгууллагадаа сэтгэл ханамж өндөр байдаг.
5. Бие, биеэ хүндэтгэсэн,оюун ухааны чадвартай, эвсэг, ирээдүй харсан хамт олонтой байхыг хүсдэг

Сэтгэл ханамжийн судалгааны явцад гарсан санал хүсэлтийн дагуу хийсэн ажил:

1. Нийслэлийн Түргэн Тусламжийн Төвийн санхүүгийн албанаас ажилчин албан хаагчдад цалингийн талаар болон нийгмийн даатгалын тооцоолол, дэвтрийн бичилт, зээлийн материал бүрдүүлэх тодорхойлолтын санхүүгийн ажлын ачааллыг тооцоолж 7 хоног бүрийн 1 3, 5 өдрүүдэд мэдээллийг өөрийн биеэр санхүүгийн ажилтнаас мэдээлэл авах боломжоор хангасан.
2. .2015 онд нийт 450 эмч, ажилтнуудад 178,107,990 төгрөгийн улирлын нэмэгдэл, цалингийн урамшуулал олгоод байна.
3. Эмч, эмнэлгийн ажиллагсдад ажлын хувцасны захиалгыг “Би ИксТи” ХХК, Цргттуул ХХК -тай гэрээ хийж, инженер техникийн ажиллагсдад 70 хос зуны ажлын хувцас, эмч халаад 25 ширхэг, эмч сувилагчдын ажлын нимгэн өмд, цамц 87 хос эмчийн өвлийн 39 хос хувцас захиалгаар хийлгэсэн. Нийт өртөгт 19.320.400 төгрөг зарцуулсан



4. Дугуйн аялал зохион байгуулж байгууллагаас дэмжлэг үзүүлж 100.000 төгрөг зарцуулсан



5. Байгууллагын аварга шалгаруулах 4 төрөлтийн тэмцээн зохион байгуулж, Үйлдвэрчний Эвлэлийн Хороо шагнал урамшуулалд 1,000 000 төг зарцуулсан.




6. 2015 онд манай байгууллагын нийт 55 эмч, эмнэлгийн ажилтнууд дараах шагналуудаар шагнагдсан. Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан-9, Эрүүл мэндийн яамны жуух-9, Нийслэлийн эрүүл мэндийн газрын тэргүүний ажилтан цол тэмдэг-9, Нийслэлийн эрүүл мэндийн газрын өргөмжлөл-16, Онц тээвэрчин-4, Зам тээврийн яамны жуух-3, Монголын залуучуудын холбооны Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч-3, Хөдөлмөрийн алдар-1
7. Өнөөдрийн байдлаар дуудлага хүлээн авах, дуудлагын карт бичилтэнд 20 компьютер ашиглагдаж байгаа боловч шаардлага хангахгүй байгаа тул Эрүүл мэндийн яам, Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй Цахим эрүүл мэнд төслийн шугамаар хуваарилагдсан компьютерээс 12 ширхгийг нэмснээр, эмч нарын карт бичилт сайжирч, зөрчил арилна. Жолооч нарын ажлын хувцасны угаалгын асуудлыг шийдвэрлэх боломжийг судалж байна. Нэгдсэн угаалгатай болохын тулд 24,000,000 төгрөгийн санхүүжилт хэрэгтэй байна.
8. Ажилчдын бялдаржуулах өрөөг тохижуулж гүйлтийн зам 650.000 төгрөгөөр, хөлийн булчин чангалагч 80.000 төгрөгөөр авч нэмэлт тохижилт хийсэн.
9. Нийслэлийн иргэдэд үзүүлэх түргэн тусламжийн үйлчилгээг чадавхижуулахад Япон улсын туршлагыг нэвтрүүлэх нь сэдэвт уулзалт ярилцлагыг 2015 оны 01 сарын 15-нд Нийслэлийн засаг даргын тамгын газрын хурлын танхимд зохион байгуулсан.



10. Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа байгууллага, Шуурхай удирдлагын төв, Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын нийт 60 төлөөлөгч оролцож, Япон улсын доктор профессоруудтай “Яаралтай тусламжийн тулгамдсан асуудлууд” сэдвээр 1 өдрийн уулзалт ярилцлага зохион байгуулав. Цаашид Япон улсын Түргэн тусламжийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах, Япон улсын Токио хотод эмч, эмнэлгийн ажилтан явуулж туршлага солилцох ажлын гарааг амжилттай эхэлсэн .



11. Солонгос улсын Сөүл хотын Ortoped plastik hospital-д сургалтын менежер Д.Бат-Ундрах, эмч Б.Эрдэнэболор нар “Үе шилжүүлэн суулгах” мэс заслын чиглэлээр 1 жилийн мэргэжил олгох дамжаанд суралцаж ирсэн.



12. Сувилахуйн албаны дарга Б.Танацэцэг Солонгосын Сөүл хотын Тэжонсон эмнэлгийн урилгаар 2015 оны 06 сарын 30-наас 07 сарын 6-ны хооронд танилцах аялалд явж, эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар туршлага судалж ирсэн. Манай байгууллага 2016 оны 1-р сард Франц улсад 10 эмч, эмнэлгийн ажилтан, 2-р сард ХБНГУ-д 7 жолооч, техникийн ажилтнуудыг тус тус мэргэжил дээшлүүлэх сургалтад явуулахаар төлөвлөөд байна.

1. Хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн тухай.
2. 2015 оны 1-р сарын эм, эмнэлгийн хэрэгслийн зарлагыг судалж үзэхэд 122 эмч ажилласан байна. Нийт 4,924,683 төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл зарлагадсан байна. Нийт дуудлага 24525. Өөрөөр хэлбэл 1 удаагийн дуудлагад 200 төгрөг, 80 мөнгөний эм, эмнэлгийн хэрэгсэл зарцуулж байна.
3. 2015 оны 03 сарын 23-24 нд шөнийн 01 цагаас 04 цагийн хооронд Сонгинохайрхан, Баянзүрх, Төв салбарын үйл ажиллагаа, координаци, дуудлагын ачааллыг шалгаж, жолооч нарын 30%-д архи, согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг тусгай

төхөөрөмжөөр шалгасан. Зөрчил илрээгүй. Ажлын ачаалал маш их байсан. Удирдлагад танилцуулсан.

4. Нийслэлийн түргэн тусламжийн төвийн дуудлагын хуудас бичилтэд гарч буй зөрчлийг бууруулах, арилгах зорилгоор Дэд захирал С. Ариунболдоор ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг “Дуудлагын хуудас шалгах” ажлын удирдамж Захирлаар батлуулан 4 сарын 1-ээс 6 сарын 15 хүртэл хугацаанд шалгаж, долоо хоног бүрийн эмч нарын ярианд мэдээлэл хийсэн. Энэ хугацаанд нийт 12 удаагийн үзлэгээр 3800 карт шалгасан. Үүнд: Үр дүнгүй дуудлага 29,5%-иас 6,3% болж % иар 5 дахин буурсан. Үр дүнгүй дуудлагыг дотор нь авч үзэхэд 56-60% нь өөрсдөө эмнэлэг явсан эсвэл буцаасан. Энэ байдлаас харахад иргэд гарцаагүй, шаардлагатай, яаралтай эмнэлгийн тусламж авах эсэх талаар эрүүл мэндийн хангалттай мэдлэггүйн улмаас бидний үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна. Дуудлагын хуудас бичилт хэдийгээр сайжирсан боловч байгууллагын зүгээс эмч нарт ажлын төгсгөлд дуудлагын хуудсаа бичих компьютерээр хангах шаардлагатай байна. Одоогийн байдлаар 13-16 эмчийн дунд 3 компьютер ажиллаж байна.
5. Үр дүнгүй дуудлагын дотроос гэртээ байгаагүй, өөрсдөө эмнэлэг явсан гэх шалтгаантай карттай танилцан тэмдэглэсэн утсаар холбогдож тусламжийн талаар лавлахад эхний үед дуудлагын хуудас худлаа хаасан зөрчил илэрч байсан. 2, 3 дахь хяналтаас эхлэн зөрчил арилсан.
 - Сувилахуйн алба болон сувилахуйн чанарын багаас нийт 17 удаа дотоод хяналтыг явуулсан.
Мэргэжлийн үнэлгээ 4 удаа хийгдсэн. Дотоод хяналт болон мэргэжлийн үнэлгээгээр хийгдсэн ажлуудыг дор дурьдвал:
 - 2015 оны 01 дүгээр сарын 25 ны өдөр Сонгинохайрхан салбар дээр сувилагч Ч. Ариунцэцэг, У.Булганцэцэг нар ажилд гарахаар ирсэн нийт 8 машины ариун цэвэр, машины тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг шалгахад хангалттай сайн үнэлгээ авсан ба жолооч нарын хувцаслалт, энгэрийн тэмдэг, техник ашиглалт сайн, ялангуяа жолооч Пэлжид, Шинэзагд нарын хүчилтөрөгч ашиглалтын дэвтэр хөтлөлт сайн байсан.
Дуудлагын эмч, сувилагч нарын хувцаслалт, энгэрийн тэмдэг, цаг ашиглалт зэрэгт явцын шалгалт хийхэд бүгд бүрэн өмсөж хэвшсэн.
 - 2015 оны 02 дугаар сарын 10, 17 –ны өдрүүдэд Чанарын алба, Халдвар хяналтын албатай хамтран Сонгинохайрхан, Баянзүрх, Төв салбаруудад дотоод хяналт хийсэн. Хяналтаар Сонгинохайрхан салбараас 22, Баянзүрх, салбараас 11, Төв салбараас 15 зөрчил илрүүлж гарсан зөрчлүүдийг арилгах талаар газар дээр нь арга зүйн зөвлөгөө өгч зөрчил арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг бичгээр авсан.
 - 2015 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр эмийн сангийн сувилагч нар 122 эмчийн цүнхний эм тарианы хугацаанд гэнэтийн шалгалт хийж 23 эмчийн цүнхнээс хугацаа дууссан 6 төрлийн 38 ампултай тариаг хураан авч устгалд оруулсан.
 - 2015 оны 05 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд эмийн сангийн сувилагч нар ижил мэргэжилтний үнэлгээг Төв, Баянзүрх, Сонгинохайрхан салбаруудын эмийн сангуудад явуулсан. Үнэлгээг эм тарианы хаягжилт, эм тарианы бүрдэлд, ариутгал халдваргүйтгэлийн гүйцэтгэл чанар, эмийн орлого, зарлагын дэвтэр хөтлөлт зэрэг үзүүлэлтээр хийсэн.
Үнэлгээгээр :
 1. Эм тарианы хаягжилт - 36 %
 2. Эм тарианы бүрдэлт - 34%

3. Ариутгал халдваргүйтгэлийн гүйцэтгэл чанар - 89 %

4. Эмийн орлого, зарлагын дэвтэр хөтлөлт - 53 % тай үнэлэгдсэн.

Үнэлгээгээр эмийн хаягжилт хангалтгүй, бор цаасан уутнууд урагдсан, шахмал эмийг задгай хийсэн, эм тариа дутуу цэнэглэсэн, нэр хаяг он сар нь арилсан зэрэг нийтлэг алдаанууд гарсан.

Сонгинохайрхан салбарын 1-р ээлжийн эмийн санч Б. Энхбаатар нь 2015 оны 05 дугаар сарын 19 нд ариутгалыг хийгээгүй, Төв салбарын 3-р ээлжийн эмийн санч С. Эрдэм мэдлэг нь 2015 оны 05 дугаар сарын 18 нд хийсэн ариутгалын он сар гарын үсгийг зарим багажны гадна талын бор уутан дээр бичилт хийгээгүй байсан.

Эмийн сангуудын халдвар хамгааллын хувцас шаардлага хангахгүй, хангамж хүрэлцээгүй, хүүхдийн өлгийний хангалт байхгүй байна гэсэн дүгнэлт хийсэн.

- 2015 оны 05 дугаар сарын 22, 2015 оны 06 дугаар сарын 03 ны өдрүүдэд хуваарийн дагуу Баянзүрх, Сонгинохайрхан, Хан уул, Төв салбаруудад эмнэлэг үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагаанд шалгалт үнэлгээ хийж, газар дээр нь илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар зөвлөгөө, хугацаат үүрэг даалгавар өгч биелэлтийг эргэн шалгасан.
- Ариутгалын бүртгэлийн дэвтрийг ЭМС-ын 2014 оны 09 сарын 02 өдрийн Халдварын сэргийлэлт, хяналтыг сайжруулах тухай 187 дугаар тушаалын дагуу шинэчлэсэн.
- 2015 оны 5 дугаар сард Баянзүрх салбарын сувилагч Д.Пүрэвсүрэн I-р ээлжийн нийт 12 эмчийн цүнхэнд үзлэг хийж зөрчлүүдийг арилгасан.
- Эмийн зарлагын хуудсанд 6 удаа шалгалт хийсэн. Шалгалтаар өвчтөний овог нэрийг бүтэн бичдэг эсэх, картны ID, онош, эмийн нэршил бүрэн зөв бичдэг эсэх, тарилгыг хаана хийсэн, тариур, биксэнд авсан эм тариагаа тэмдэглэсэн эсэх гэсэн үзүүлэлтээр шалгахад эмийн зарлага бичилт дутуу, тарилгыг хаана хийснээ бичдэггүй, биксэнд авсан эм тариагаа дутуу бичдэг зэрэг зөрчлүүд илэрсэн байна. Илэрсэн зөрчлүүдийг алдаа гаргасан эмч, сувилагч нарт нь анхааруулж алдаа зөрчлүүд багассан.
- 2015 оны 05 дугаар сарын 21- ны өдөр эмийн санч Б. Алтанцэцэг, Ч.Энхжаргал нар Төв салбарын II болон III ээлж, Баянзүрх салбарын бүх ээлжийн эмч, сувилагч нарын нийт 47 эмчийн цүнхний эмх цэгц, эм тарианы бүрэн бүтэн байдал, хадгалалт, хугацаа, ариутгал, дэвтэр хөтлөлтөд хяналт явуулж 24 зөрчил илрүүлэн, илэрсэн зөрчлүүдийг алдаа гаргасан эмч, сувилагч нарт нь анхааруулсан.
- 2015 оны 08 дугаар сарын 14-17 ны өдрүүдэд сувилагч Д. Пүрэвсүрэн Сонгинохайрхан салбарын бүх ээлжийн эмчийн цүнхэнд шалгалт хийн хугацаа нь дууссан эм тариаг илрүүлэн устгалд оруулсан.
- 2015 оны 09 дүгээр сард сувилагч Г.Ариунсайхан Хан Уул салбарын бүх эмч нарын дуудлагын цүнхэнд шалгалт хийн хугацаа нь дууссан эм тариаг илрүүлэн устгалд оруулсан ба 4 эмчийн цүнхний цахилгаан эвдэрсэн байсныг солиулсан.
- 2015 оны 09 дүгээр сард эмийн санч нар ижил мэргэжилтний үзлэг хийсэн. Үнэлгээгээр эмийн хаягжилт хангалтгүй, бор уутнууд урагдсан, шахмал эмийг задгай хийсэн, эм тариа дутуу цэнэглэсэн, нэр хаяг он сар нь арилсан зэрэг нийтлэг алдаануудыг
- 2015 оны 10 дугаар сард нийт сувилагч нарын дунд тарилгын стандартаар ижил мэргэжилтний үзлэг хийсэн. Үзлэгт нийт 29 сувилагч хамрагдсан. Сувилагч нарын ажлын бэлтгэл, хувцаслалт, бикс болон эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдал 100%, үйлчлүүлэгчтэй харилцах, эелдэг харилцаа тогтоох байдал 100%, эмчийн бичсэн эм тариаг стандартын дагуу хийх 100% , зарлагын хуудас хөтлөлт 80% , эмийн

орлого зарлагын дэвтрийн хөтлөлт 90%, эмийн орлого зарлагын дэвтрийг гаргацтай цэвэр нэг өнгийн балаар хөтөлсөн эсэх 60%, тусламж үзүүлсэн байдал 100% гэж үнэлэгдсэн.

- 2015 оны 11 дүгээр сард Төв салбарын эмийн санч нар 45 эмчийн цүнхний эмх цэгц, эм тарианы бүрэн бүтэн байдал, хадгалалт, хугацаа, ариутгал, дэвтэр хөтлөлтөнд хяналт явуулахад зөрчил илрээгүй.
- 2015 оны 11 дүгээр сард сувилагч Ч.Ариунцэцэг Хан Уул салбарын 3 ээлжийн эмч нарын цүнхний бэлэн байдал, эм тарианы бүрэн бүтэн байдал хаягжилт зэргийг шалгаж 5 зөрчил илрүүлэн алдааг газар дээр нь арилгасан. Мөн 8 жолоочийн автомашины тоног төхөөрөмжийн бэлэн байдал, ариун цэвэрт дотоод хяналт явуулж илэрсэн зөрчлийг арилгасан.



- 2015 оны 11 дүгээр сарын 03-18 ны өдрүүдэд Чанарын алба, Сувилахуйн алба, Халдвар хяналтын алба, Техникийн алба хамтран дотоод хяналтын хуваарийн дагуу эмнэлэг үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагаанд шалгалт үнэлгээ хийж ажилласан.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хийсэн дотоод хяналтын үнэлгээгээр Баянзүрх салбар 170 оноо 49.2% буюу “ дунд эрсдэлтэй”, Сонгинохайрхан салбар 43 оноо 12.4% буюу “ бага эрсдэлтэй”, Хан уул салбар 137.5 оноо 39.8% буюу “дунд эрсдэлтэй”, Төв салбарын Б.Халиунаа ахлагчтай I ээлж 232.5 оноо 69.4 % буюу “их эрсдэлтэй”, Б.Айболат ахлагчтай II ээлж 220 оноо 63.7% буюу “их эрсдэлтэй”, Т.Өнөржаргал ахлагчтай III ээлж 116.5 оноо 33.7% буюу “дунд эрсдэлтэй”, эм зүй, эрүүл ахуй, халдвар хамгаалал, ажиллагсдад тавих ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмд хийсэн дотоод хяналтын үнэлгээгээр Баянзүрх салбар 28 оноо 7.9% буюу “ бага эрсдэлтэй” Сонгино хайрхан салбар 10 оноо 2.8 % буюу “ бага эрсдэлтэй”, Хан- уул салбар 57 оноо 23.2 % буюу “ бага эрсдэлтэй”, Төв салбарын эмийн санч Ч.Энхжаргал , Б.Алтанцэцэг, Б.Энхбаатар нар 29.5 оноо 9.9% буюу “ бага эрсдэлтэй” гэж дүгнэгдсэн.

Гардан үйлдлийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг булчин тарилгын гүйцэтгэлээр шалгахад Баянзүрх салбарын их эмч Ууганбаатар 60% буюу D үнэлгээ, Хан- уул салбарын их эмч Д. Нямсүрэн 36.6 % буюу F үнэлгээ, Сонгинохайрхан салбарын их эмч Б.Болорбаяр 76.6 % буюу C үнэлгээ, Төв салбарын I ээлжийн их эмч Э. Амаржаргал 82.6 % буюу B үнэлгээ, сувилагч Н.Отгонбаатар 89.1% буюу B үнэлгээ, II ээлжийн их эмч Г.Цэндбаяр 76% буюу C үнэлгээ, сувилагч Д.Чойдогжамц 82.6% буюу B үнэлгээ, III ээлжийн сувилагч Д.Төмөртулга 93.4% буюу A үнэлгээ авсан.

- Гар угаах гүйцэтгэлийг шалгахад Баянзүрх салбарын их эмч н.Ууганбаатар 84% буюу B үнэлгээ, сувилагч н.Долгион 96% буюу A үнэлгээ, жолооч н.Түвшиндэлгэр 88% буюу B үнэлгээ, Хан- уул салбарын их эмч Э.Энхболд 90% буюу A үнэлгээ, жолооч н.Улаанаа 80 % буюу B үнэлгээ, Сонгино хайрхан салбарын их эмч Ж.Эрдэнэчимэг 92% буюу A үнэлгээ, эмийн санч С.Эрдэммэдлэг 80% буюу B үнэлгээ, жолооч Д.Амгаланбаатар 100% буюу A үнэлгээ, Төв салбарын I ээлжийн их эмч Э.Амаржаргал

96% буюу А үнэлгээ, сувилагч Н.Отгонбаатар 94% буюу А үнэлгээ, жолооч Ж.Золжаргал 96% буюу А үнэлгээ, II ээлжийн их эмч Г.Цэндбаяр 88% буюу В үнэлгээ, сувилагч Д.Чойдогжамц 92% буюу А үнэлгээ, жолооч Э.Төмөрбаатар 92% буюу А үнэлгээ III ээлжийн их эмч н.Цэрэнчимэд 80% буюу В үнэлгээг тус тус авсан.

6. Удирдамжтай шалгалт 2 удаа

a. Төвийн дуудлагын хуудас бичилтэд гарч буй зөрчлийг бууруулах, арилгах зорилгоор Дэд захирал С.Ариунболдоор ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг “Дуудлагын хуудас шалгах” ажлын удирдамж Захирлаар батлуулан 4 сарын 1-ээс 6 сарын 15 хүртэл хугацаанд шалгаж, долоо хоног бүрийн эмч нарын ярианд мэдээлэл хийсэн. Энэ хугацаанд нийт 12 удаагийн үзлэгээр 3800 карт шалгасан. Үүнд: Үр дүнгүй дуудлага 29,5%-иас 6,3% болж % иар 5 дахин буурсан. Үр дүнгүй дуудлагыг дотор нь авч үзэхэд 56-60% нь өөрсдөө эмнэлэг явсан эсвэл буцаасан

b. Төвийн нийт эмч нарын газар дээрх тусламж үйлчилгээ болон эмнэлэг хүртэл үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор “Газар дээрхи болон эмнэлэг хүртэл үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, эмийн зохистой хэрэглээнд хяналт тавих” аяны удирдамж Дэд захирлаар батлуулан 2015 оны 09 сарын 05 аас 2015 оны 10 сарын 20 ны хооронд зохион байгуулсан.

Явцын шалгалт 142 удаа хийсэн. Үүнд: Чанарын алба 40, салбарууд 64, Авто бааз 30, Хүүхдийн мэргэжилтнүүд 8 удаа тус тус үзлэг, хяналтыг хийж илэрсэн зөрчлийг арилгасан.



7. Эрүүл мэнд спортын сайдын 2015 оны 11 сарын 16 өдрийн Сахилга, дэг журам, үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай 449 тоот тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төвийн Захирлын 2015 оны 12 сарын 01-ний өдрийн Сахилга, дэг журам, үйлчилгээг сайжруулах тухай тушаал гарч ажлын төлөвлөгөө гарган, салбаруудад ажлын бус цаг, амралтын өдрөөр хяналт хийх хуваарь гаргаж баталгаажуулсан. 7 хоног бүрийн Даваа гарагт хяналтын тайланг нэгтгэн хэлэлцэнэ.



9. Байгууллагын үйл ажиллагааны статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн байдал, үр дүн

ТТТөвийн 2015 оны үндсэн үйл ажиллагааг өмнөх оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлт

Д/Д	Үндсэн үзүүлэлт	2014 он		2015 он		Харьцуулалт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
А	Нийт дуудлага	283108	100%	306478	100%	23370	7.6%
Үүнээс	Насанд хүрэгчдийн дуудлага	245329	86.7%	270537	88.3%	25208	1.6%
	Хүүхдийн дуудлага	37779	13.3%	35941	11.7%	-1838	-1.6%
Насанд хүрэгчдийн дуудлага	Үр дүнгүй дуудлага	9900	4.0%	11270	4.2%	1370	0.2%
	Төрөх	24387	9.9%	23567	8.7%	-820	-1.2%
	Осол гэмтэл	36431	14.8%	44266	16.4%	7835	1.6%
	Өвчлөл	174611	71.2%	191434	70.8%	16823	0.4%
В	Яаралтай дуудлага	163709	66.7%	191014	70.6%	27305	3.9%
20 минутын очилт		122364	74.7%	147646	77.3%	25282	2.6%
Энгийн дуудлага		81620	33.3%	79523	29.4%	-2097	-3.9%

Нийт дуудлагын 20 минутын очилт		62151	76.1%	64956	81.7%	2805	5.6%
C	Гэрийн төрөлт	102	0.4%	126	0.5%	24	0.1%
D	Нас баралт /нийт/	2143	0.9%	2286	0.8%	143	0.1%
Зүрхний шигдээс		4468	1.8%	4169	1.5%	-299	-0.3%
Тархины цус харвах		504	0.2%	445	0.2%	-59	0.01%
Даралт ихдэх		30002	12.2%	32864	12.1%	2862	0.1%
Хоол шингээх эрхтэний бусад		7406	3.0%	9014	3.3%	1608	0.3%
Умайн цус алдалт		465	0.2%	419	0.2%	-46	0.01%
Бусад эрхтэний цус алдалт		152	0.1%	133	0.1%	-19	0.1%
Амьсгалын замын цочмог халдвар		9422	3.8%	13191	4.9%	3769	1.1%
Бөөр шээсний замын бусад		9045	3.7%	10656	3.9%	1611	0.2%
Халдварт өвчин		852	0.3%	3851	1.4%	2999	1.1%
Хорт хавдар		4956	2.0%	5327	2.0%	371	0.01%
Сэтгэцийн өвчлөл		1320	0.5%	1172	0.4%	-148	-0.1%
Бусад		99248	40.5%	103295	38.2%	4047	2.3%






2015 оны нийт дуудлага **7,6%**-иар өсөж үүнээс насанд хүрэгчдийн дуудлага 1.6%, хүүхдийн дуудлага 1.6%-иар буурсан байна. Яаралтай дуудлагын 20 минутын очилт өнгөрсөн оноос 2.6 хувиар нэмэгдсэн нь өдөрт үйлчлэх түргэн тусламжийн багийн тоо 35 хувиар нэмэгдсэнтэй холбоотой. Насанд хүрэгчдийн дуудлагаас үр дүнгүй дуудлага 0.2% нэмэгдэж, төрөхийн дуудлага 1.2%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Нийт дуудлагын 70.6%-ийг яаралтай, 29.4%-ийн энгийн дуудлага тус тус эзэлж яаралтай дуудлаганд очих 20 минут 77.3% буюу 2.6%-иар ахисан байна. Өвчлөлийн үзүүлэлтээс амьсгалын замын өвчлөл 3769 буюу 1.1%-иар, халдварт өвчин 1.1%-иар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


д/д	Үндсэн үзүүлэлт	2014 он		2015 он		Харьцуулалт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
А	Салбаруудын нийт хүүхдийн дуудлага	77697	100%	72399	100%	-5298	-7.3%
Үүнээс	Явж үзсэн дуудлага	37736	48.6%	33938	46.9%	-3798	-1.7%
	Амбулатор	39961	51.4%	38461	53.1%	-1500	1.7%
	Утсаар зөвөлгөө өгсөн	69181		54059		-15122	
	Яаралтай дуудлага	2221	5.9%	2538	7.5%	317	1.6%
	20 минутын очилт	2112	95.1%	2432	95.8%	320	0.7%

В	Өвчлөл	37736	48.6%	33938	46.9%	-3798	-1.7%
Үүнээс	Нярайн эмгэг	1606	4.3%	1480	4.4%	-126	0.1%
	Мэдрэлийн эмгэг	1456	3.9%	1457	4.3%	1	0.4%
	Амьсгалын замын эмгэг	22485	59.6%	18461	54.4%	-4024	-5.2%
	Хоол боловсруулах замын эмгэг	3847	10.2%	3830	11.3%	-17	1.1%
	Мэс заслын эмгэг	459	1.2%	384	1.1%	-75	-0.1%
	Халдварт өвчин	364	1.0%	775	2.3%	411	1.3%
	Бусад өвчин	7519	19.9%	7551	22.2%	32	2.3%


Хүүхдийн дуудлагын үзүүлэлт





Хүүхдийн өвчлөлийн үзүүлэлт






Яаралтай дуудлагын үзүүлэлт



Дүгнэлт: Салбаруудын нийт хүүхдийн үзүүлэлт нь явж үзсэн дуудлага болон амбулаторийн үзлэг орж байгаа бөгөөд БЗС,СХС-ын үзүүлэлт нь 7.3-иар буурсан байна. Энэ нь амбулаториор ирж үзүүлэх хүүхдийн үзлэг буурсантай холбоотой. Нийт дуудлаганд эзлэх яаралтай дуудлага 7.5%-ийг эзлэж байгаа нь 103-т хандаж байгаа хүүхдийн дуудлагын 92.5% нь энгийн буюу өрхийн дуудлага байна. Салбарууд хүүхдийн яаралтай дуудлаганд очих 20 минутын үзүүлэлт 95.8% байгаа нь өмнөх оноос 0.7% -иар өссөн байна. Хүүхдийн өвчлөлөөс 54.4%-ийг амьсгалын замын эмгэг эзлэж байгаа нь өндөр үзүүлэлт. Мөн 2015 онд хүүхдийн халдварт өвчин 411 буюу 1.3%-иар нэмэгдэж, хоол боловсруулах эрхтний эмгэг 1.1%-иар буурсан байна.




Дүгнэлт: 2015 онд нийт дуудлагын 14.4%-ийг осол гэмтлийн дуудлага эзлэж байгаа бөгөөд осол гэмтлийн үед үзүүлэх тусламж шархны цэгцэлгээ 376.буюу 1.0%, боолт 278 буюу 2.0%-иар өссөн байна. Зүрх судас болон мэдрэлийн хурц эмгэгийн дуудлага нь 12.2% буюу 0.2%-иар нэмэгдсэн. энэ үед үзүүлэх эмнэлгийн анхны тусламж нь буурсан үзүүлэлттэй. Бусад өвчлөлийн үзүүлэлт нь 4047 буюу 1.4%-иар нэмэгдэж өвчтөнд газар дээр нь үзүүлэх тусламж үйлчилгээ нь 5.2%-иар өсөж эмнэлэг хүргэх тээвэрлэлт нь 4.9%-иар буурсан.



Дүгнэлт: 2015 онд хүүхдийн дуудлаганд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ өмнөх оноос өссөн бөгөөд ХӨЦМ-ийн дагуу хүүхдийн биеийн байдлыг зөв үнэлснээр шаардлагагүй эмнэлэг хүргэлт 1.1%-иар буурч, эцэг эх болон иргэдэд эмийн хэрэглээ болон хүүхдийн асаргааны талаар зөвөлгөө өгснөөр бусад хэлбэрийн тусламж 12.8%-иар нэмэгдсэн байна.

**2015 оны дуудлагын хүлээгдэлийг
өмнөх оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлт**


Үзүүлэлт		2014 он		2015 он		Харьцуулалт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт дуудлага		245886	1009%	298692	100%	52806	3.1%
Хүлээгдэлийн МИНУТ	0-20 минут	69835	28.4%	81691	27.3%	11856	1.1%
	21-40 минут	68577	27.9%	74242	24.9%	5665	3.0%
	41-60 минут	91573	37.2%	133358	44.6%	41785	7.4%
	61-с дээш минут	15901	6.5%	9401	3.1%	-6500	-3.4%




Дүгнэлт: Дуудлагын хүлээгдэлийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад 61-с дээш минутны хүлээгдэл 3.4%-иар буурч, 0-20 минутны хүлээгдэл 1.1%, 21-40 минутны хүлээгдэл 3.0%-иар тус тус өссөн байна.

➤ Хан-Уул салбарын алсын дуудлаганы судалгаа хийсэн.


Хороодын дуудлага болон эмнэлэг зөөгдсөн дуудлага /тоогоор/



дүүргийн хэмжээний нийт дуудлага болон алсын дуудлаганы харьцаа тоогоор.



ӨДРИЙН ДУНДАЖ ДУУДЛАГА БОЛОН АЛСЫН ДУУДЛАГАНЫ ХАРЬЦАА




Дүгнэлт:

10, 12, 13, 14-р хороодын дуудлаганы тоог нийт дуудлагатай харьцуулахад харьцангуй бага буюу 7,6% байна.

Ажлын цагаар 10-с дээш км явж үзэж байгаа дуудлагнуудын ихэнхи нь буюу 54,1% нь ерхийн эмнэлэгт үзүүлэх боломжтой дуудлага байна.

Өдөрт дунджаар 6 дуудлагыг 10-с дээш км явж үзэж байгаа бөгөөд 6 дуудлагны 3 нь зөөгдөж байгаа нь 5 машинд харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлт юм.




ЦААШИД:






- Дээрхи үзүүлэлтээс харахад дуудлагын хүлээгдэл болон гэрийн төрөлт, хүлээгдэлээс шалтгаалсан нас баралт, гомдол гарах эрсдэл өндөр байна.
- Тухайн хороодын дуудлагыг өрхийн эмчээс авч байх.
- Төрөх болон Осол гэмтэлийн дуудлаганд ХУС-с явж байх
- Эдгээрийг хэрэгжүүлж чадвал машины бензин дуусах мөн хүлээгдэлээс шалтгаалсан асуудлуудын эрсдэл буурна.


➤ Онгоц тосох үеийн дуудлаганд судалгаа хийсэн.

Нийт дуудлага ба онгоцны дуудлагын харьцаа /90 хоног/



Өдрийн дундаж дуудлага ба онгоцны өдрийн дундаж дуудлагын харьцаа.






Дүгнэлт:

- ХУС нь 24 цагаар 3, 16 цагаар 2 машин үйлчилдэг. Онгоцны дуудлага нь сарын дундаж дуудлагатай харьцуулахад харьцангуй бага хувьтай гарж байгаа ч, өдрийн дундаж дуудлагатай харьцуулахад өндөр хувьтай, эргэлтийн дундаж нь ердийн дуудлагаас 2 дахин удаан, ачаалалын цагаар буюу 16-00 цагын хооронд их дуудаж байгаа нь зохиомолоор ачаалалыг ихэсгэж санал гомдол гаргах, хүлээгдэл үүсгэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Дүгнэлт: 2015 оны 6 дугаар сард нийт 26076 дуудлага ирснээс ослын 3656 буюу 14%-ийг эзлэж байна. Ослын 3656 дуудлаганаас архины хордлоготой 523 буюу 14,3% үүнээс 205 буюу 39,1%-ийг эмнэлэгт хүргэсэн, согтуугийн 426 буюу 11,6% үүнээс 273 буюу 64,0%-ийг эмнэлэгт хүргэж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Төрөх, төрсний дараах болон зулбасан зэрэг эх барих, эмэгтэйчүүдтэй холбоотой дуудлаганд дараалал харгалзахгүй шуурхай үйлчилж, шаардлагатай тусламжийг хугацаа алдахгүй үзүүлж ирлээ.


2015 оны байдлаар нийт 306478 дуудлага ирсэнээс төрөхийн дуудлага 23567 буюу нийт дуудлагын 7.7%-ийг төрөх дуудлага эзэлж байна. 2014 оны байдлаар нийт 283108 дуудлага ирсэнээс төрөхийн дуудлага 24387 буюу нийт дуудлагын 8,6%-ийг төрөх дуудлага эзэлж байна. Урьд оныхтой харьцуулах юм бол 820 буюу 0,9%-иар буурсан үзүүлэлт гарч байна.



ЭМНЭЛГИЙН БУС НӨХЦӨЛД ТӨРСӨН ТӨРӨЛТ


2014 онд гэрийн төрөлт 102 буюу 0,4% гарч байсан бол 2015 онд 126 буюу 0,5%-ийг эзэлж байна. Урьд оныхтой харьцуулбал 24 буюу 0,1%-иар өссөн үзүүлэлттэй байна. Энэ гэрийн хаягжилт болон хожимдож дуудсантай холбоотой байна.

2014,2015 оны гэрийн төрөлтийг харьцуулсан нь:



	2014 он	2015 он
■ хувиар	0.40%	0.50%
■ гэрийн төрөлт	102	126
■ нийт төрөх дуудлага	24387	23567

гэрийн төрөлтийг дүүргээр нь харьцуулж гаргавал



Үүнээс үзэхэд баянгол дүүрэг 13%-иар ихэссэн, баянзүрх дүүрэг 4,8%-иар буурсан, чингэлтэй дүүрэг 15,8%-иар ихэссэн, хануул дүүрэг 17,5%-иар ихэссэн, сүхбаатар дүүрэг 7,3%-иар буурсан, сонгинохайрхан дүүрэг 12,4% -иар ихэссэн үзүүлэлт гарч байна. Энэ нь:


1. Иргэдийн эрүүл мэндийн боловсрол дутмаг
2. Жирэмсний хяналт сул
3. Гэрийн хаягжилт тодорхой бус
4. Алслагдсан хороонд амьдардаг
5. Тулгаж дуудсан зэрэг хүчин зүйлсүүд нөлөөлж байна.

Гэрийн төрөлтийн талаар сургалт байнга зохион явуулж ажиллаж байна. Мөн гэрийн төрөлтийн мэтгэлцээн зохион байгуулсан.

ХҮҮХДИЙН НАС БАРАЛТ

2015 онд нийт 23 нас баралт гарсан. Эдгээр бүх нас баралт нь дуудлагын их эмч очихоос өмнө нас барсан ба нас баралтыг тодорхойлсон бичиг хийн 102 дуудаж үлдээсэн.

2014 онд 46 хүүхдийн нас баралт гарсан байсан. 2015 оны 12 сарын 01-ний байдлаар нийт 23 хүүхдийн эндэгдэл гарсан. 2014 онтой харьцуулахад хүүхдийн эндэгдэл 50% буурсан харагдаж байна. СХС-ын нас баралт 3 дахин буурсан тоон үзүүлэлт харагдаж байна.



Нийт 23 эндэгдлийн 21 тохиолдол буюу 91.3% нь 0-5 насны хүүхэд байна. Нийт 0-5 насны 21 эндэгдлийг дараахь байдлаар: 0-5 насны хүүхдийн 23 эндэгдэл дотроо нярайн насны хүүхэд 7 тохиолдол буюу 33.3% эзэлж байна.

Хүйсээр нь үзэхэд: эрэгтэй 12 буюу 57.1%, эмэгтэй 9 буюу 42.8% байна.

Өвчлөлөөр нь үзэхэд:

Дутуу нярай-3 (14.2%)

Мэдрэлийн эмгэг, зүрхний төрөлхийн гажиг-5 (23.8%)

Хөхөөрөө дарсан юм шиг-3 (14.2%)

Гэнэтийн буюу шалтгаан тодорхойгүй-10 (47.6%) байна.

Яаралтай дуудлагын 20 минутийн очилтын байдлыг харахад: 2015 оны 23 хүүхдийн нас баралтаас 20 минутын дотор очилт нь 19 буюу 82,6% байна.

10. Ололт амжилт, бүтээлч ажил, сурталчилсан байдал

- Гадна талбай, дотор орчны шаардлагатай хэсгийг хянах зорилгоор гадна талд хяналтын 2 камер, гараж дотор 14 хяналтын камерын суурилуулсан. Дотоод хяналтын камер нь 24 цагийн бичлэг хийгдэж, нийт 48 хоног хадгалагдах сервертэй. Ингэснээр дотоод хяналт сайжирч, ажилчдын ажиллах тухтай орчин нөхцөл бүрдэж байна.



- Гадна болон дотор талд эмнэлгийн байрыг байнга хянах зорилгоор камерийн системийг тавьж байршуулсан байгаа. Нийт 8 газар камер байршуулсан байгаа. Үүнд : гадна талд 2ш, дотор талд давхар бүр камертай болсон.



- 2015 оны 05 дугаар сарын 28-нд Хан-Уул салбар үйл ажиллагаа эхлэн хан-уул дүүргийн иргэдэд түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлснээр хүлээгдэл өмнөх саруудаас 8.9 хувиар буурсан.

- 2015 оны 06 сарын 06-ны өдөр Найрсаг Улаанбаатарын хүрээнд зохион байгуулагдсан “Улаанбаатар-марафон-2015” арга хэмжээнд эмнэлгийн бүрэн тоноглогдсон автомашинтай 8 их эмч, 4 сувилагч, 4 жолооч нийт 16 хүний бүрэлдэхүүнтэй баг 07:30-17:00 цагийн хооронд ажилласан. Ажиллах хугацаандаа нийт 16 үйлчлүүлэгч хандсанаас Артерийн даралт ихсэлтэй-3, зөөлөн эдийн гэмтэлтэй-5, өнгөц шархтай-4, тархины доргилттой -4 хүнд эмнэлгийн тусламж үйлчилгээг газар дээр нь шуурхай үзүүлж ажилласан.



- “Дэлхий нийтээрээ тамхигүй” өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажилчдын хүүхдүүдэд эх эцгээ хайрлаж , хүндлэх ёс зүй, хүүхдүүдийг дам тамхидалтаас сэргийлэх эрүүл орчин, гэр бүл төлөвшүүлэх зорилгоор БЗД-н салбар дээр 5 сарын 31 нд “ХҮҮХДИЙН ЕРТӨНЦӨД ИНЭЭД НЭМЬЕ” нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж 38, хүүхэд эцэг эхчүүдэд үзлэг шинжилгээ хийж зөвлөгөө өгч 400 ширхэг гарын авлага бичгийн хэрэглэл тараасан./ жин өндөр сахар үзэж тодорхойлсон



- “Сувилагч шинэчлэгч хүч, үр дүнтэй, үр ашигтай тусламж”, “Эмнэлгийн болон сувилахуйн тусламж үйлчилгээнд тулгамдсан асуудал” сэдэвт эрдмийн чуулганыг 2015 оны 05 дугаар сарын 08- ны өдөр Нийслэлийн түргэн тусламжийн төвийн сургалтын танхимд зохион байгуулсан.

Эрдмийн чуулганыг нээж Нийслэлийн түргэн тусламжийн төвийн захирал Ц.Пүрэвдаш үг хэлсэн. Шүүгчээр хяналт үнэлгээний албаны дарга , клиникийн профессор, эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх эмч С.Баясгалан, сургалт эрдэм шинжилгээний ажилтан анагаах ухааны доктор Л.Энхбаатар нар ажилласан.



- Нийслэлийн иргэдэд үзүүлэх түргэн тусламжийн үйлчилгээг чадавхижуулахад Япон улсын туршлагыг нэвтрүүлэх нь сэдэвт уулзалт ярилцлагыг 2015 оны 01 сарын 15 нд зохион байгуулсан.



- Их эмч Х.Мөнгөнхараа 03 сарын 01-ээс 05 сарын 01 хооронд ХБНГУ-ын Эссэн хотын эмнэлэг, гал унтраах төвд 24/48 цагаар ажиллаж туршлага судалсан бөгөөд “Эмнэлгийн эрүүл ахуйн” судалгаа хийсэн.



- 2015 оны 06 сарын 13-19-ны хооронд ХБНГУ-ын Эссэн хотын Яаралтай тусламжийн төвийн ахлах мэргэжилтэн Арнд Рейнсмантай хамтарч Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 10 жолооч нарт:
 1. Амилуулах суурь тусламж
 2. AED дефибрелятор ашиглах
 3. Сургалтын видео хичээл зэргийг хийсэн.



- 2015 оны 6 сарын 18-нд Монгол германы хамтарсан “Яаралтай тусламж, эмнэлгийн эрүүл ахуйг сайжруулах” төслийн хүрээнд “Халдварын сэргийлэлт, хяналт” гуравдугаар зөвлөгөөнийг ЭМСЯ, АХБ, Түргэн тусламжийн төв нар амжилттай зохион байгуулсан. ХБНГУ-ын проф.Попп, проф Вайдхас, проф Ёхум, Түргэн тусламжийн мэргэжилтэн Арнд, Эрүүл ахуйн тасгийн эрхлэгч Ноуза нар уригдан ирсэн бөгөөд сонирхолтой илтгэлүүд тавигдсан. Үүнд: Нийслэл болон хөдөө орон нутгийн харьяа байгууллагуудын тархвар судлаач, эмч эмнэлгийн ажилчид хамрагдсан.



- НЭМГ-ийн тэмцээнд амжилттай оролцож нийлбэр дүнгээр багаараа 2р байр



- 2015.01.24 НЭМГ-ын харьяа байгууллагуудын дунд зохиогдсон цасны баярт багаараа оролцож 3-р байранд орсон.



- 2015.02.27-28 хооронд “Эрүүл мэнд шинэчлэл” ТББ-аас зохион явуулсан нийт орон нутгийн 49 –н эрүүл мэндийн байгуулга оролцож Нийслэлийн түргэн тусламжийн төв 103-ийн эмэгтэй баг 3-р байранд шалгарч амжилттай оролцсон мөн төр захиргааны авто баазуудын дунд зохиогдсон тэмцээнд амжилттай оролцож мөнгөн медаль авсан.



- Нийслэлийн Засаг Даргын 162 тоот тушаалыг үндэслэн нийтийн биеийн тамирыг эрчимтэй хөгжүүлэх ажилчин албан хаагчдын багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, “Цэвэр агаар, хөдөлгөөн эрүүл мэнд “ Дугуйн аяллыг 2015 оны 5р сарын 26 нд зохион байгуулж явуулсан.
- Нийслэлийн түргэн тусламжийн төвийн үүсэн байгуулагдсны түүхт 85 жилийн ойн арга хэмжээ, хүндэтгэлийн хурал 2015 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 10:30 минутанд Нийслэлийн Улаанбаатар Чуулгын концертын их танхимд ёслол төгөлдөртэйгээр эхэлсэн. Хуралд нийт 140 гаруй гавяаныхаа амралтанд гарсан ахмад ажилчид, 140 эмч ажилчид, 20 гаруй зочид төлөөлөгчид хүрэлцэн ирсэн. Үүнд урилгаар ЭМСЯ-ын сайдын зөвлөх Л.Одончимэд, НЭМГазрын эмнэлгийн тусламжийн албаны дарга Б.Батцэцэг, тус төвийн үе үеийн дарга нар болон НЭМГарын харьяа дүүргийн Эрүүл Мэндийн Нэгдлийн дарга нар хүндэтгэлтэйгээр ирж оролцсон. Баярын хурлыг тус төвийн захирал Ц.Пүрэвдаш байгууллагын түүхт 85 жилийн хөгжлийн талаар товч илтгэл тавьж зочидод баяр хүргэн нээж үг хэлсэн.



- Ойн баярын хуралд уригдан ирсэн Эрүүл Мэнд Спортын Яамны сайдын зөвлөл н.Одончимэд баяр хүргэн үг хэлж шагнал гардуулсан.



- Тус төвийн ойн хүрээнд идэвх санаачлагатай хамт олныхоо дундаас ажил хөдөлмөр урлаг спортоороо шалгарсан ажилчдыг төрийн болон салбарын шагналаар шагнаж урамшуулсан Үүнд: Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан-1, Эрүүл мэнд спортын яамны жуух-5, Нийслэлийн эрүүл мэндийн тэргүүний ажилтан-3, Нийслэлийн эрүүл мэндийн газрын өргөмжлөл-5, Спортын дэд мастер-2, Нийслэлийн 375 жилийн ойн медаль-1, Онц тээвэрчин-2, Авто тээврийн салбар үүсч хөгжисний 90 жилийн ойн медаль-14 хүнийг тус бүр шагнаж урамшуулсан. Шагналыг тус төвийн захирал Ц.Пүрэвдаш болон хүндэт зочид гардуулж өгсөн.



- 85 жилийн ойг угтан тус төвийн захиргаа Номгон санчир авто сургуультай хамтран нийт жолооч нарыг мэргэшсэн жолоочийн сургалтанд суулгаж амжилттай төгссөн

жолооч нарт мэргэшсэн жолоочийн үнэмлэх гэрчилгээ олгосон.



- Нийслэлийн Түргэн Тусламжийн Төвийн 85 жилийн ойтой холбоотой нийт ажилчдын дунд урлагийн их наадам зохион байгуулж амжилттай оролцож түрүүлсэн шилдэг номеруудаар баярын концерт бэлтгэн баярын хуралд ирсэн зочид төлөөлөгч нарт сонирхуХүндэтгэлийн баярын концерт нь зочдын сэтгэлд хүрсэн сайхан тоглолт болж өндөрлөлөө. Баяр хурлын үйл ажилгаа өндөрлөсний дараа “INGRAD” рестранд 13:00-аас хүрэлцэн ирсэн ахмад настан болон Эмч, Жолооч, Инженер техникийн ажилчдыг хүндэтгэлийн зоогонд оруулсан. Орой 18:30-аас Захиргааны ажилчид, Урилгаар хүрэлцэн ирсэн зочдын хамт оройн зоог барьж баярын үйл ажиллагаа амжилттай болж өндөрлөлөө.
- 60 жолоочийг мэргэшсэн жолоочийн сургалтанд 14.100.000 төгрөгөөр хамруулсан. Одоо хоёр дахь ээлжийн сургалтанд 60 жолоочийг 14.100.000 төгрөгөөр сургаж байна. Сургалтанд нийт 28.200.000 төгрөг зарцуулан “Түргэн тусламжийн төвийн мэргэшсэн жолооч” тусгай сертификат, үнэмлэх олгосон.
Энэ сургалтаар анхан шатны тусламжийг хэрхэн зөв үзүүлэх, автомашины ариутгалын хоёр хувингийн арга, автомашины эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, замын хөдөлгөөний дүрэм, журам, хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг эзэмшин төгссөн. Ингэснээр түргэн тусламжийн жолооч нь автомашин барихаас гадна анхны тусламж үзүүлэх чадвартай болно.




АСЕМ-ийн чуулга уулзалттай холбогдуулан байгууллагын эмнэлэг үйлчилгээний эмч, сувилагч, жолооч болон хариуцлагатай ажилтан болох 41 хүн хамрагдаж 10.701.000 төгрөгний Англи хэлний анхан, дунд шатны 29 хоногийн сургалтанд хамруулсан.



- Автотээврийн салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойн нэрэмжит жолооч нарын болзолт уралдаан зарлаж 2280000 төгрөгийн урамшуулал, мөнгөн шагнал олгосон. Дээрхи болзолт уралдааны зорилго нь нийт жолооч нарын бие бялдар, хоорондын харьцаа хандлага, багаар ажиллах чадварыг сайжруулахад оршино..
- Тухайн жилд мэдээлэл технологийн чиглэлээр сургалт, судалгаа, программын шинэчлэл, системийн шинэчлэл, компьютерийн бүртгэл, тооллого, цахим хуудасны

шинэчлэл зэрэг олон ажлууд хийгдсэн. Мөн мэдээлэл технологийн журмуудыг шинэчлэн боловсрууллаа.

- Байгууллагын цахим хуудсанд цаг алдалгүй мэдээ мэдээллийг шинэчлэн ажиллаж байна.



- Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа техник программ хангамжийн саадгүй ажиллагааг бүрэн хангаж ажиллахын тулд мөн мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд байгууллагын нийт компьютерт вирусны эсрэг 1 жилийн хугацаатай /лицензтэй/ KASPERSKY Antivirus Plus - 2015 программ 21 ширхэгийг худалдан авч суулгасан.

Ач холбогдол:

- Сургалт явуулсанаар ажилчидын мэдээлэл технологи, компьютерийн хэрэглээний мэдлэг дээшилнэ.
- Компьютер, тоног төхөөрөмжийн судалгаа гаргаснаар хэрэгцээнд шаардлагатай байгаа төхөөрөмжүүдийг тодорхойлох, цаашид төлөвлөх.

- Программ болон системийн шинэчлэл хийснээр эрсдэл, гэмтэл багасах,
- Вирусны эсрэг программ суулгаснаар ажилчидын хэрэгцээт мэдээлэл, файлыг вирусээс бүрэн хамгаалж чадаж байна.

- Байгууллагын FACEBOOK хуудсыг идэвхитэй ажиллуулж байна. Уг хуудсаар нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, байгууллагын мэдээлэл, статистик мэдээлэл, зөвлөгөө, талархал, олон нийтийн ажил зэрэг мэдээлэл оруулан ажиллаж байна. Одоогийн байдлаар 3315 Like хүрсэн байна.



- НТТТ-ийн хэмжээнд бүх /5/ салбар дотоод сүлжээ болон гадаад интернэтийн сүлжээнд холбогдсон. Байгууллагын дотоод сүлжээ байнга ашиглаж өөр хоорондоо сүлжээг ашиглан мэдээлэл, файл дамжуулан ашигладаг.

Дотоод сүлжээний хурд-100Mbps,
Нийт дотоод сүлжээнд холбогдсон 103 төвд 26, Автобазад 16, Баянзүрх салбарт 11, СХД салбарт 8 байна.

Тухайн жилд төсвийн хөрөнгөөр 3ш компьютер, 3ш принтер шинээр худалдан авч суурилуулсан.

- Бүх оффисын ажилтнуудын компьютер интернэтэд 100 хувь холбогдон ажиллаж байна. Хурд 6 mbps. Интернетийн үйлчилгээг Ситинэт ХХК-аас авдаг. Бүх компьютер 100% холбогдсон. Интернэт ашиглалт сайн.





Шинэчлэгдсэн цахим хуудас

Цахим хуудасны шинэчлэлт:

- Байгууллагын цахим хуудсыг нээлттэй эхийн програм дээр шинэчлэн хийж байршуулан мэдээ мэдээллээр баяжуулан ажиллаж байна. Цахим хуудсанд байх шаардлагатай мэдээ мэдээлэл багтсан.
- 2015 онд байгууллагын цахим хуудсыг тогтмол шинэчлэн ажиллаж байна. Цахим хуудсанд байгууллагын ил тод байдлын мэдээ мэдээлэл, иргэд үйлчлүүлэгчдэд хандсан нийгмийн эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл, байгууллагын дотоодод болж буй мэдээлэл, чанарын булан, гадаад харилцаа, дуудлагын статистик мэдээлэл, сургалт сурталчилгаа, эрүүл мэнд, анхан шатны тусламжийн зөвлөгөө, сэрэмжлүүлэг, хууль эрх зүйн зөвлөмж бичих болон байгууллага, үйл ажиллагаагаа сурталчлах зорилгоор өөрийн байгууллагын танилцуулга, бүтэц зохион байгуулалт, үүсэл хөгжил гэх мэт олон мэдээ мэдээллээр баяжуулан ажиллаж байна.

Цахим хуудасны хандалтын тоолуур:



Зураг, видео байрлуулсан эсэх:

- Зурагтай мэдээлэл болон Видео мэдээлэл тогтмол байршуулан ажиллаж байна.

ВИДЕО МЭДЭЭЛЭЛ	ВИДЕО ЗӨВЛӨГӨӨ
<p> Гар угаах болон халдваргүйжүүлэх дараалал</p> <p> Эрүүл мэндийн дэд сайд Амарсанаа ЯТТ-д ажиллаа.</p> <p> НЯТТ- бүрэн тоноглогдсон автомашинтай боллоо.</p> <p> НЯТТ-103</p> <p> Нийслэлийн 375 жилийн параданд оролцож 3-р байр эзэллээ.</p>	<p> Анхны тусламжийн зөвлөгөө</p> <p> Амилуулах суурь тусламж</p> <p> Усанд живсэн хүнд үзүүлэх яаралтай тусламж</p> <p> Нярай хахах үед үзүүлэх тусламж</p> <p> Ухаангүй хүнд үзүүлэх тусламж</p> <p> Осол гэмтэлийн үеийн зөвлөгөө</p> <p> Томуу өвчнөөс гэргийлэх зөвлөмж</p>

Вэб сайтанд сургалтын файлын сан ажиллуулж байгууллагын дотоод болон гадаад сургалтын мэдээллүүдээр шинэчлэн ажиллаж байна.

Гарчиг	Зохлогч	Үзсэн
Амьсгалын дутмагшлын хэлбэрүүд, яаралтай тусламж	Бичсэн Super User	24
Тархины дутмагшил	Бичсэн Super User	17
Хичээл: Шокын үеийн яаралтай тусламж	Бичсэн Super User	90
Хичээл: Кесарево хагалгааны дараах умайн сорвин дээрх жирэмсэлт	Бичсэн Super User	76
Хичээл: Цус алдалт, эх барих эмэгтэйчүүд	Бичсэн Super User	89
2014.05.07 - Сэтгэлд нийцсэн үйлчилгээ /Хичээл/	Бичсэн Super User	75
2014.04.30 - Эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж /Хичээл/	Бичсэн Super User	370
2014.02.19 - Хэвлийн битүү гэмтэлийн хичээл	Бичсэн Super User	102
Шарх гэж юу вэ? ЛНЯТТ-ийн их эмч Б.Эрхэмболд	Бичсэн Super User	157
Тархинд цус харвах үеийн шинж тэмдгүүд оношлох	Бичсэн Super User	214

Хуудас 2 - с 1

Хичээл сургалтын материалыг оруулснаар эмч, ажилчид цахим хуудсаар дамжин сургалтын материалаа авч байна.

Вэб сайтанд заавал байх зүйлсүүдийг ажиллуулж байгаа эсэх:

- Байгууллагын нэр, танилцуулга, лого, эрхэм зорилго, зорилт, бүтэц зохион байгуулалт, дагаж мөрдөх хууль,
- Санхүүгийн тайлан баланс, аудынтын дүгнэлтийн мэдээлэл,
 - Шинэ мэдээ мэдээлэл, эрүүл мэндийн зөвлөгөө зөвлөмж,
 - Анхны тусламжийн зөвлөгөө мэдээлэл

➤ ЭБОЛА вирус тэй холбоотой мэдээлэл зөвлөгөө



Холбоо барих утас, хаяг, байршил, вэб холбоос,





- Статистик мэдээ, мэдээлэл,
- Талархал, өргөдөл, гомдлын мэдээлэл
- Сул орон тооны зар, хүний нөөцийн мэдээлэл
- FACEBOOK, YOUTUBE, TWITTER зэрэг олон нийтийн сүлжээ ашиглан мэдээлэл дамжуулах холбоос.

/FACEBOOK – хуудсаар дамжуулан мэдээ мэдээллийг тогтмол оруулж байна. Одоогийн байдлаар 2396 дагагчтай болсон байна./

- Их уншигдсан болон шинээр нэмэгдсэн мэдээний булан,
- Дарга нарын иргэдтэй уулзах цагийн хуваарь, даргын мэндчилгээ



- Видео болон зурагт зөвлөгөө мэдээлэл,

ВИДЕО МЭДЭЭЛЭЛ	ВИДЕО ЗӨВЛӨГӨӨ
<ul style="list-style-type: none"> Гар угаах болон халдваргүйжүүлэх дараалал Эрүүл мэндийн дэд сайд Амарсанаа ЯТТ-д ажиллаа. НЯТТ- бүрэн тоноглогдсон автомашинтай боллоо. НЯТТ-103 Нийслэлийн 375 жилийн параданд оролцож 3-р байр эзэллээ. 	<ul style="list-style-type: none"> Анхны тусламжийн зөвлөгөө Амилуулах суурь тусламж Усанд живсэн хүнд үзүүлэх яаралтай тусламж Нярай хахах үед үзүүлэх тусламж Ухаангүй хүнд үзүүлэх тусламж Осол гэмтэлийн үеийн зөвлөгөө Томуу өвчнөөс гэргийлэх зөвлөмж

- Холбоотой байгууллагын холбоосууд.
- Чанар болон ёс зүйн хорооны булан



- Ил тод байдлын мэдээ мэдээлэл зэрэг цахим хуудсанд байх шаардлагатай мэдээллийг багтаан тогтмол ажиллуулж байна.

Вэб сайт сурталчлах үйл ажиллагаа хэрхэн явуулсан: Байгууллага болон вэб сайтыг сурталчлах зорилгоор FACEBOOK, TWITTER, YOUTUBE зэрэг олон нийтийн сүлжээнд Page хуудас, аккаунт нээж мэдээ мэдээлэл, видео зэрэг байршуулан ажиллуулж байна. Телевиз радиогоор эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны нэвтрүүлэгт орсон байгууллагын эмч, ажилчдаарээр дамжуулан цахим хуудсыг сурталчилж байна. Мөн вэб сайтыг ард иргэдэд таниулах зорилгоор дуудлагын эмч



нараар дамжуулан иргэдэд тараах материал тараалган өгсөн.

- Ээлж хамт олны дунд "Номын баяр" зохион байгуулж мэргэжлийн холбогдолтой номоо солилцсон.
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангаж ажилах, Баянзүрх салбарын чанарын талоны хэрэгжилтийг сайжруулах зорилгоор 1,0*0,90

хэмжээтэй 16500 төгрөгийн өртөг бүхий чанарын талоны хэрэгжилтийн самбарыг шинээр хийж байршуулсан.



- Автобаазад галын аюулгүй байдлыг хангах үүднээс нөөц хаалгыг тодорхой болгож, гал унтраах хэрэгслээр бүрдүүлсэн. Үүнд : MFZ галын хорыг 30 ширхэг, ISO ABC галын хорыг 5 ширхэг шинэчилсэн.



- Жолооч Б.Батхүүгийн санаачилгаар жолооч нарт өдөр тутамд нь хэрэглэгдэх гарын авлага хэвлүүлэн 60 ширхэгийг тараасан. Үүний үр дүнд жолооч нарын тусламж үйлчилгээний чанар сайжирч байна.



- Нийслэлийн түргэн тусламжийн төв болон “Тэн Хун” ХХК-н хамтын ажиллагааны 01 тоот гэрээний дагуу 2015 оны 08 сарын 20-21 өдрүүд болох 2 өдрийн нарийн мэргэжлийн

үзлэгийг тус ХХК ажлын байранд 10 их эмч, 2 сувилагч жолооч 08.00-17.00 цагуудад нийт 229 ажилтанд үзлэг шинжилгээ хийсэн.

- Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсны дагуу, тамхины тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр нийт ажилчдаас тамхи татдаг хүмүүсийн судалгаа гаргасан . Тамхи татдаг 80 ажилтантай 1 –1,5 жилийн гэрээ хийж гарын үсэг зуруулж хяналт тавьж, сургалт явуулж, болзолт уралдаан зарлаж өдөрлөг зохион байгуулж ажилласны үр дүнд нийт 29 ажилчин тамхинаас бүрэн татгалзаж тус бүр 1 сарын цалингийн урамшуулал авсан.80 - 100 % 29 - 36,25 % нь тамхинаас татгалзсан 63,75 % нь ажлын байр,байгууллагын хашаанд тамхи татахгүй хэрэглээг багасгасан.


Судалгаагаар өдөрт 1 хүн дунджаар 1 хайрцаг тамхи татдаг 3000 төгрөгний үнэтэй сард 90000 төгрөг, жилд 1080000 төгрөгний тамхи татдаг бол 29 ажилчин өдөрт 87000 төгрөг, сард 2610000 төгрөг жилд 31320000 төгрөгний эдийн засгийн болон эрүүл мэнддээ маш их хөрөнгө оруулалт хийсэн.



- Төв салбарт зарлал, мэдээллийн урсдаг самбар байрлуулж өдөр тутмын дуудлагын тоо,өвчлөл, тухайн өдөр ажиллаж буй ажилчдын мэдээллийг тогтмол гаргаж, удирдах ажилтнуудын ажлын чиг үүрэг, танилцуулгыг тогтмол шинэчилсэн.

11. Бусад байгууллагуудын сайн туршлагыг судалж хэрэгжүүлсэн талаар.

- Онлайн сургалтыг нэвтрүүлснээр телемедицин ашиглан алслагдсан аймгуудын ижил төст үйл ажиллагаа явуулдаг 186 эмч, сувилагч, жолооч нарт сургалт явуулсан.



- ХБНГУ-ын Эссэн хотын Гал унтраах, түргэн тусламжийн мэргэжилтэн Арнд Рейнсмантай хамтарч эмч, сувилагч, жолооч нарт зориулан сургалтын видео хичээл бэлтгэж өдөр тутмын сургалтдаа ашиглаж байна.



- Эмнэлгээс шалтгаалах халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн дэглэмийг сахих зорилгоор “Гурван хувингийн аргыг” нэвтрүүлж байна.



- Төвдийн Од-сэр Ринбүчийн хандиваар “Иог, бясалгалийн өрөө”-г дараах байдлаар тохижуулснаар ажилчдын алжаал тайлах, стрессээс ангижрах таатай орчин бүрдсэн.

- Зохицуулагч А.Алтанзагас өөрийн санаачлагаар “Түргэн тусламжийн төвийн эмч нарын ажлын байрны сэргээн засалт сэдэвт төсөл бичиж сургалтын өрөөг тохижуулав. Мөн Нийслэлийн Түргэн Тусламжийн төвд ажилладаг нэг жолооч, нэг үйлчлэгч нарт хүнсний зүйл өгж , эмч нарт гарын бэлэг гардуулав.




- Ёс зүй, харьцаа хандлагатай холбоотой сургалтуудыг сургалтын жилийн төлөвлөгөөнд тусгаж “Эмчийн харьцаа ёс зүй” “Эмнэлгийн ажилтны хандлага” “Харилцааны соёл” сэдэвт сургалтууд нийт 4 удаа зохион байгуулж давхагдсан тоогоор 520 ажилтныг хамруулсан. Сургалтын үр дүнд ёс зүй харьцаа хандлагатай гомдол 32,5 хувиар буурсан.
- Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 92-р тушаалын дагуу ёс зүйн хэсгийн хорооны хэсгийн хорооны дүрэм шинэчлэгдсэнтэй холбоотой ёс зүйн хорооны гишүүдийг шинэчилж, төлөвлөгөө гаргаж ажилласан. “Сэтгэлийн хөг “төрийн бус байгууллагаас нийт эмч, сувилагч нарт “Эмч, эмнэлгийн ажилтнуудын эмнэлзүйн болон ёс зүйн алдаа, зөрчлөөс сэргийлэх” болон амьдралын зөв дадал эзэмших анхан шатны мэдлэг олгох сургалт зохион байгуулсан.



- 2015 оны 8 дугаар сарын 25-наас 8-дугаар сарын 29-ныг хүртэлхи хугацаанд Баянзүрх салбарын эрхлэгч Д.Бат-Ундрахын санаачлагаар Нийслэлийн түргэн тусламижийн төв, АМДА-олон улсын байгууллага, Япон улс Китакусью женерал хоспитал, Фукуока мужийн яаралтай тсламж хариуцсан захирал Кийчий Нагаминэ нарын дэмжлэгтэйгээр Яаралтай тусламжийн чиглэлээр хамтарсан сургалтыг зохион байгуулсан. Энэхүү сургалтаар:




1. Цус харвалт өвчний үед үзүүлэх яаралтай тусламж,
2. Зүрхний шигдээсийн үед үзүүлэх яаралтай тусламж
3. Ухаангүй үеийн ялган оношлогоо
4. Цус эргэлтийн хямрал буюу шокийн үед үзүүлэх яаралтай тусламж
5. Хүүхэд болон нярайн яаралтай тусламж
6. Гамшигийн үеийн газар дээрхи эрэмбэлэн ангилалт сэдвээр Япон эмч нар хэрхэн яаралтай тусламж үзүүлдэг талаар хамтарсан сургалтыг зохион байгууллаа.



- Ингэснээр дэлхийн өндөр хөгжилтэй улс оронд үзүүлэх тусламж үйлчилгээний онцлог, өөрийн орны тусламж үйлчилгээний онцлогыг харьцуулан дүгнэх, харилцан туршлага солилцох, цаашид хамтран ажиллах зэрэг олон олон боломжуудыг бий болгосон ихээхэн үр дүнтэй сургалт болсон. Сургалтад 2,3-р ээлжийн нийт эмч, сувилагч нар хамрагдсан ба 114 эмч, сувилагч нар хамрагдсан. Цаашид хамтарсан сургалтууд зохион байгуулах, харилцан туршлага солилцох зэрэг олон асуудлаар хамтран ажиллахаар тохиролцсон.
- Сонгино хайрхан салбарын чанарын багтай хамтран Сонгино хайрхан дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл, Сонгинохайрхан дүүргийн Өрхийн эрүүл мэндийн нэгдлүүдтэй гурвалсан холбоогоор ажиллаж, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулж байна. Гурвалсан холбоогоор ажиллуулснаар Сонгинохайрхан дүүргийн хүүхдийн мэргэжилтэн болон өрх тус бүртэй хамтран ажиллаж, зарим өвчтэй хүүхдийн талаар мэдээлэл солилцож байгаа нь хүүхдийн өвчлөлийн хүндрэлээс сэргийлэх, нас баралтыг бууруулахад чухал ач холбогдолтой болж байна.
- 2015 оны 3 дугаар сарын 8-11-нд “Монголын хүүхдийн эмч нарын зөвлөлдөх уулзалтын” төлөөлөгч нар ирж туршлага солилцлоо. ЭМЯ-ны хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, НЭМГ-ийн хүүхдийн асуудалт хариуцсан мэргэжилтэн Бадамханд болон зөвлөлдөх уулзалтын төлөөлөгч Сонгинохайрхан салбарын хүүхдийн түргэний үйл ажиллагаатай танилцаж, ажлыг сайнаар үнэллээ.




- 2015 оны 6-р сард Сонгино-Хайрхан дүүргийн өрхийн эмнэлгүүдтэй хүүхдийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор дуудлага ихтэй болон үйл ажиллагаагаараа доголдолтой өрхийн эмнэлгийн удирдлагатай уулзалт хэлэлцүүлгийг удирдамжийн дагуу хийж гүйцэтгэлээ. Уг хэлэлцүүлгийг чанарын албанаас Сонгинохайрхан дүүргийн хүүхэд, өрх хариуцсан менежерүүдтэй хамтран зохион байгууллаа.



- Хан-Уул салбар Хүүхдийн дуудлага авахтай холбогдуулан эрэмбэлэн ангилалтын туузыг Солонгос улсаас судлан үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Ажлын явц 70%-т

- Их эмч Ё.Отгонжаргал англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор энэтхэг улсад 3 сарын хугацаанд суралцсан.
- Их эмч Ө. Цэрэнлхам БНСУ-ын Хэт авиан нийгэмлэгээс зохион явуулдаг KSUM 2015 хурал, семинарт Монгол улсад 2011-2014 онуудад зонхилон тохиолдох ургийн гажгийн илрүүлэлт сэдвээр ханын илтгэл тавьж оролцсон. Үүний үр дүнд оношилгооны үр чадвар сайжирч байна.



- Бүгд Найрамдах Солонгос улсын Тэжон хотын Тэжонсон эмнэлгийн урилгаар зохион байгуулагдсан “Эмнэлгийн ажилтны ёс зүй, харилцаа хандлага” сэдэвт 5 хоногийн хөтөлбөртэй эрүүл мэндийн байгууллага хоорондын туршлага судлах уулзалт аялалд 2015 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 2015 оны 07 дугаар сарын 05 ны хооронд байгууллагын зардлаар сувилахуйн албаны дарга хамрагдаж сувилахуйн тусламж үйлчилгээнийн хандлага сайжирсан.
- Medic Diagnosis аппликэшнд олон улсын ICD 10 дугаар ангилал дахь бүх оношын кодын монгол, орос, англи нэршлийн хамт оруулсан.
- Таны утасны давтагдашгүй код серверт бүртгэгдсэнээр таны утасны өгөгдлийн сан устгах, үйлдлийн системийг сэргээсэн тохиолдолд бид идэвхжүүлэх кодыг үнэ төлбөргүй явуулах болно.
- Medic Diagnosis аппликэшний шинэ хувилбар гарсан тохиолдолд танд дахин үнэ төлбөргүй суулгаж өгнө. Цаашид тогтмол хөгжүүлэлт хийгдэж, хэрэглэхэд хялбар, энгийн загвартай. Medic Diagnosis аппликэшнийг ашигласанаар Хэвлэмэл хэлбэрийн толь бичгээс үсгийн дарааллаар эрэмблэгдсэн талбараас үг хайхад дунджаар 30 секунд зарцуулдаг гэсэн судалгаа байдаг тул эмч нар ухаалаг утсандаа суулгаж оношийн алдаа зөрчил буурч ажиллаж байна.
- 2015 оны 10 сарын 27-ны өдөр JICA олон улсын байгууллагын 3 төлөөлөгч Нийслэлийн түргэн тусламжийн төвөөр айлчилж, 2 орны газар дээрх болон эмнэлэг хүртэлх түргэн тусламжийн хүрээнд санал солилцож, өөрийн байгууллагын үйл ажиллагааг танилцуулсан. 10 сарын 29-ны өдөр “Joint conference of emergency medicine in Mongolia and Japan” зөвлөгөөнд оролцсон. Тус зөвлөгөөний хүрээнд Монголын яаралтай тусламжийн тогтолцоо, Японы яаралтай тусламжийн тогтолцоо, төгсөлтийн дараах яаралтай тусламжийн сургалтын талаар санал хэлэлцэж, цаашид яаралтай тусламжийн сургалтанд Япон улсын туршлагыг нэвтрүүлэхэд хөтөлбөр боловсруулж, газар дээрх болон эмнэлэг хүртэлх эмнэлэгийн тусламж үйлчилгээг сайжруулах талаар хэлэлцсэн.



12. Байгууллагын үйл ажиллагааг дэмжсэн төсөл, хөтөлбөр

- Монгол улсын Засгийн газрын 2010 оны 318 тоот “Түргэн тусламжийн сүлжээ” хөтөлбөрийн хүрээнд нэгдсэн төлөвлөгөө гарган биелэлт 92 хувьтай байна. Үүнд: Нийслэлийн иргэдэд үзүүлэх түргэн тусламжийн үйлчилгээг чадавхижуулахад Япон улсын туршлагыг нэвтрүүлэх нь сэдэвт уулзалт ярилцлагыг 2015 оны 01 сарын 15 нд зохион байгуулсан.



- Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа байгууллага, Шуурхай удирдлагын төв, Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын нийт 60 төлөөлөгч оролцож, Япон улсын доктор профессоруудаас “Яаралтай тусламжийн тулгамдсан асуудлууд” сэдвээр 20 асуулт, “Түргэн тусламж зохион байгуулалт, тулгамдсан ” 15 асуулт тавьж хялбар аргаар хэрхэн асуудлуудыг шийдэх талаар хариулт авсан. Цаашид Япон улсын Түргэн тусламжийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах, Япон улсын Токио хотод эмч, эмнэлгийн ажилтан явуулж туршлага солилцох ажлын амжилттай эхэлсэн .
- Эмч Х.Мөнгөнхараа 03 сарын 01-ээс 05 сарын 01 хооронд ХБНГУ-ын Эссэн хотын эмнэлэг, гал унтраах төвд 24/48 цагаар ажиллаж туршлага судалсан бөгөөд “Эмнэлгийн эрүүл ахуйн” судалгаа хийсэн.



- 2015 оны 06 сарын 13-19-ны хооронд ХБНГУ-ын Эссэн хотын Яаралтай тусламжийн төвийн ахлах мэргэжилтэн Арнд Рейнсмантай хамтарч Нийслэлийн түргэн тусламжийн 10 жолооч нарт:



1. Амилуулах суурь тусламж
2. AED дефибреллятор ашиглах

3. Сургалтын видео хичээл зэргийг хийсэн.

- 2015 оны 6 сарын 18-нд Монгол германы хамтарсан “Яаралтай тусламж, эмнэлгийн эрүүл ахуйг сайжруулах” төслийн хүрээнд “Халдварын сэргийлэлт, хяналт” гуравдугаар зөвлөгөөнийг ЭМСЯ, АХБ, Түргэн тусламжийн төв нар амжилттай зохион

байгуулсан. ХБНГУ-ын проф.Попп, проф Вайдхас, проф Ёохум, Түргэн тусламжийн мэргэжилтэн Арнд, Эрүүл ахуйн тасгийн эрхлэгч Ноуза нар уригдан ирсэн бөгөөд сонирхолтой илтгэлүүд тавигдсан. Үүнд: Нийслэл болон хөдөө орон нутгийн харьяа байгууллагуудын тархвар судлаач, эмч эмнэлгийн ажилчид хамрагдсан.



- Солонгос улсын Сөүл хотын Ortoped plastik hospital-д сургалтын менежер Д.Бат-Ундрах, эмч Б.Эрдэнэболор нар “Үе шилжүүлэн суулгах мэс заслын” чиглэлээр 1 жилийн олгох курс хийж ирсэн.



- 2015 оны 06 сарын 30-аас 07 сарын 6-ны хооронд сувилахуйн албаны дарга Б.Танацэцэг Солонгос улсын Сөүл хотын эмнэлэгт эмнэлэг үйлчилгээний талаар сургалтад хамрагдаж байна..
- 2010 оноос ХБНГУ-ын Эссэн хотын Гал унтраах яаралтай тусламжийн төвтэй хамтарч эмнэлгийн туслах ажилтан парамедик бэлтгэх сургалтын хөтөлбөр гарган ажиллаж байна.



Үүнд:

1. Аврах албаны эрүүл ахуй
2. Халдваргүйтгэл, ариутгал
3. Шархны эмчилгээ, арчилгаа
4. Амьсгалын эрхтэн тогтолцоо
5. Хоол боловсруулах эрхтэн тогтолцоо
6. Цусны эргэлтийн тогтолцоо
7. Яс булчин, үений тогтолцоо
8. Өвчтөн тээвэрлэх, зөөвөрлөх
9. Эрэмбэлэн ангилалт
10. Амилуулах суурь тусламж
11. Эмнэлгийн тоног төхөөрөмжтэй ажиллах
12. Шокийн үеийн тусламж үзүүлэх



- 2014 оны 12 сарын 10-нд Япон улсын профессорын багтай хамтарч “Яаралтай тусламжийн зөвлөгөөнийг зохион байгуулахаар Японы элчин сайдын яамны нарийн бичгийн дарга Широ Токомотатай хамтарч хөтөлбөр боловсруулж ажиллаж байна.

Үүнд:

1. Япон улсын түргэн тусламжийн үйл ажиллагаа
 2. Түргэн тусламжийн төвийн бүтэц зохион байгуулалт, тулгамдсан асуудал
 3. Эмнэлгийн туслах ажилтан Парамедикийг бэлтгэх
 4. Япон улсын Токио хотын яаралтай тусламж дэвшилтэт арга
 5. Түргэн тусламжийн эмчийн өнөөгийн байдал
 6. Япон улсын түргэн тусламж, эмнэлгийн туслах ажилтны тухай
 7. Гамшгийн үед үзүүлэх яаралтай тусламж
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Эрүүл мэнд спортын яамнаас “Хурдан морь уяач хүүхдүүдийн” ослын шалтгаан, эрсдэл хүчин зүйлийг тодорхойлох төслийн хүрээнд төв болон зүүн аймгуудад морь унаач 1100 хүүхдүүдээс судалгаа авч үр дүнгий нь тооцож ЭМСЯ-д тайлагнасан.



13. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласан талаар.

Нийслэлийн түргэн тусламжийн төв нь нийт 66 байгууллагуудтай хамтран ажилласан байна. Үүнд: Олон улсын байгууллага- 4, төрийн -29, төрийн бус 18, бүрэн дунд сургууль - 6, цэцэрлэг -2, хэвлэл мэдээллийн байгууллага -7 болно.

- ХБНГУ-ын Эссэн хотын Аврах гал унтраах анги, их сургуулийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллаж “Эмнэлгийн туслах ажилтан бэлтгэх, ариутгал халдваргүйтгэлийн арга” хөтөлбөрт ажил 2 дах жилдээ үргэлжилж байна.
- Япон улс АМДА олон улсын байгууллагатай “Олныг хамарсан гамшиг ослын үед харилцан туслалцах, яаралтай тусламжийн чиглэлээр харилцан туршлага солилцох ажлын хүрээнд гэрээ байгуулсан.
- Япон улсын элчин сайдын яамтай хамтран “Яаралтай тусламжийн мэргэжилтнүүдтэй хамтарч сургалт семинар зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх JICA олон улсын байгууллагатай эмнэлэг хүртэлх тусламжийн хүрээнд санал солилцсон.
- Солонгос улсын Тежон эмнэлэгтэй яаралтай тусламжийн чиглэлээр харилцан туршлага солилцох ,хамтарсан сургалт семинар зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллах санал дэвшүүлсэн.
- Филиппин улс Манилла хот “Олныг хамарсан гамшиг болон ослын үед харилцан туслах” гэрээ байгуулан ажиллаж байна.
- ЭМЯ болон JICA олон улсын байгууллагатай хамтран Монгол Японы яаралтай тусламжийн хамтарсан зөвлөгөөн зохион байгуулсан.

- Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв “Хүүхдийн тусламж үйлчилгээ” сургалт Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 47 асрагч, ариутгалын сувилагч нарт тус эмнэлгийн эрүүл ахуйг сайжруулахад Герман улсын туршлагыг нэвтрүүлэх зорилгоор “Эмнэлгийн эрүүл ахуй” сургалт зохион явуулсан.
- Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Яаралтай тусламжийн тасагтай хамтран “Монголын яаралтай тусламжийн мэргэжилтний үндэсний чуулган”-д Түргэн тусламжийн хуудсыг шинэчлэхэд ажлын хэсэгт оролцон ажилласан.



- Нийслэлийн түргэн тусламжийн төвөөс хөдөө орон нутагт нийт 11 аймагт /Баянхонгор, Увс, Завхан, Ховд, Хэнтий, Өвөрхангай, Дорнод, Дорноговь, Сүхбаатар, Булган, Дархан/ “Амилуулах суурь тусламж болон лавшруулсан тусламж, Гэмтлийн суурь тусламж”- аар 308 цагийн сургалтыг аймгуудын Эрүүл мэндийн газар болон Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран амжилттай сайн зохион байгуулсан нийт 1650 эмч, сувилагчийг хамруулсан эдгээр сургалтаар Нийслэлийн Түргэн Тусламжийн төвийн үйл ажиллагааг хөдөө орон нутагт сурталчилж чадсан.
- Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудад сургалт орсон. Үүнд: Улаанбаатар хотын 7 дүүргийн өрхийн эмч болон сувилагч нарт “Амилуулах суурь болон лавшруулсан тусламж”- ийн сургалтад хамруулж амжилттай зохион байгуулсан.
- Удирдлагын академитай хамтран эмч, сувилагч нарын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сургалтыг зохион байгуулсан.



- Төрийн банк, Монгол банк, Шүүхийн ерөнхий шазар, Тагнуулын ерөнхий газрын ажилчид, Онцгой байдлын эмч, сувилагч, Улаанбаатар хотын дүүргийн эрүүлжүүлэх байрны эмч нарт, ДЦС2, ДЦС3, Сонгино хайрхан дүүргийн 105 цэцэрлэг, Их дээд болон ерөнхий боловсролын 14 сургууль, Тахарын албаНялхасын сувилалд гэх мэт газарт сургалтыг зохион байгуулж хүн амын эрүүл мэндийн боловсролд хувь нэмэр оруулсан.



- Улаанбаатар чуулгын 51 ажилчдад 8 чиглэлээр урьдчилан сэргийлэх үзлэг хийн эрүүл мэндийн зөвлөгөө өгсөн.

- АШУҮИС-тай хамтран ажиллаж эмнэлгийн ажилтны мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтыг зохион явуулж байгаа билээ.
- Үндэсний их баяр наадмаар НЭМГ-ын тушаалын дагуу хурдан морины уралдаан дээр эмнэлэг үйлчилгээний аюулгүй байдлыг ханган ажилласан.



- Монголын морин спорт уяачдын холбоотой хамтран Зүүн бүсийн Даншиг наадамд уяач хүүхдүүдийн аюулгүй байдал, эмнэлгийн тусламж үйлчилгээг ханган ажилласан.



- Оллоо, MNTV-ийн 120/80 нэвтрүүлэг, “Монгол телевиз -2”, HD Монгол, “Сүлд “зэрэг телевизээр “Амилуулах суурь тусламж буюу гэмтлийн суурь тусламж, хордлого болон гадны шалтгаант гэмтлүүд” зэрэг сэдвээр иргэдэд зориулсан шууд нэвтрүүлэгт 6 удаа, “Эх орон” тамхины хар хөнөөл, дам тамхидалт сэдвээр, TV 5 телевизийн “Эрүүл амьдарцаа” эрүүл мэндийн 42 удаагийн ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх нэвтрүүлэг бэлтгэгдсэн байна.



- Монголын үндэсний радиогийн хүүхдийн нэвтрүүлэгт “Анхан тусламжийг найздаа болон нөхөртөө хэрхэн зөв үзүүлэх бэ” сургалт зөвлөгөө хийсэн.
- БЗХӨ халдварт өвчнөөс сэргийлэх ажлын хүрээнд “Наран”, “Зууны билэг”, “Оюуны оньс”, “Оюуны нахиа”, “Глобал удирдагч” бүрэн дунд сургуулиудад эрүүл мэндийн сургалтыг хийсэн.




- “Чөлөөт сэтгүүлчдийн холбоо”, “Монголчууд “сэтгүүлтэй хамтран эрдэм шинжилгээний материал хэвлүүлсэн ба Дани Монголын нийгэмлэгтэй хамтран ном бэлтгэн гаргахад оролцсон.
- МУЗН-тэй хамтран хүүхэд залуучуудын дундах “Амьдралын зөв хандлага “ сургалтуудыг хамтран зохион байгуулсан.

- Сэтгэлийн хөг ТББ-тай хамтран Сонгино хайрхан дүүргийн 6,7 хорооны иргэдэд эрүүл зөв хооллолт сэдвээр нээлттэй хаалганы өдөрлөг зохион явуулсан.



- Монос, Монфа эмийн компануудтай хамтран ажиллаж сүүлийн үеийн эмчилгээний арга сургалтуудад байгууллагын эмч нарыг оролцуулсан.



- Дохионы хэл сургалтын төвтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эмнэлэг үйлчилгээ үзүүлэх зорилгоор эич нараа хамруулсан.




13. Ажилчдын 2015 оны нийгмийн асуудал шийдвэрлэсэн байдал

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа:



Урамшуулал, Нэмэгдэл:




Цалингийн хувиар урамшуулсан хүний тоо: Давхардсан тоогоор 458 үхн

Хоол унааны нэмэгдэл: 458 хүн

Нэмэгдэл									
Мэргэжлийн зэрэг					Боловсрол, цолны				
Их эмч			Сувилагч тусгай мэргэжилтэн		Их эмч			Сувилагч тусгай мэргэжилтэн	
Доктор	Тэргүүлэх	Ахлах	Тэргүүлэх	Ахлах	Профессор цолны /	Доктор	Магистр	Магистр	бакалавр
1	8	8	-	8		1	6		6
1.397.257	7.778.866	6.056.154		4.736.357.					

Сургалтын зардал:



Дотоод журмын дагуу гарсан зардал:											
Үзүүлэлт	Газар олгуулсан	Гар утас олгосон	Гэр олгосон	Ахмадын баяр	Хүүхдийн баяр	Түлээ нүүрсний хөнгөлөлт	Цалинтай чөлөө	Цалингүй чөлөө	Тэтгэмж, тусламж	Хэвтэн эмчлүүлэх ор хоногийн хөнгөлөлт	Тэтгэвэрт гарч байгаа ахмадад тусламж олгох
Хамрагдсан ажилтны тоо				196	396		8	18	15	0	5
Мөнгөн дүн				12.989.000	5,945,000				2.515.500	-	5.156.000

ХЯНАСАН:
ЗАХИРАЛ

Ц.ПҮРЭВДАШ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН :
ДЭД ЗАХИРАЛ

С.АРИУНБОЛД

